

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2017 ОНЫ
4 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2017.05.05

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид тайлант сард 3 удаа хуралдаж 14 асуудал хэлэлцэж 13 тогтоол баталлаа. Үүнд:

-”Хүнсний баталгаат байдал”, “Чацаргана” аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, “Сэлэнгэ аймагт татвар төлөгч иргэнийг бүртгэх журам”-ын хэрэгжилт болон татварын орлогыг бүрдүүлэхэд аймгийн хэлтэс, албадын оролцоо, үүргийн талаар аймгийн Татварын хэлтсийн мэдээллийг сонсож, Улс, орон нутгийн татварын орлогыг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай аймгийн Засаг дарга, аймгийн Татварын хэлтэс, аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар, аймгийн Цагдаагийн газар, аймгийн Автотээврийн төв, сумдын Засаг дарга нарт үүрэг даалгавар өглөө.

-Хот тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах, гудамж талбайг цэгцлэх, тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, инженерийн шугам сүлжээ, зам талбай байгуулах, хоггүй цэвэр орчныг бүрдүүлэхэд иргэд, айл өрх, ААНБайгууллагууд, хөршүүд хамтарч ажилладаг, орчин тойрноо хайрлан хамгаалдаг зөв хандлагатай болоход нь төрийн байгууллагын зүгээс бодлого зохицуулалтын дэмжлэг үзүүлэн хамтарч ажиллах зорилгоор “Манай гудамж-Миний гэр” хөтөлбөрийг баталлаа.

-Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцээд Сүхбаатар сумын 3, 4, 7-р багуудын зарим нутаг дэвсгэрт газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг өөрчлөхөөр тогтож, Газрыг улсын тусгай хэрэгцээнээс гаргах, хил заагийг өөрчлөх санал уламжлах тухай асуудлыг хэлэлцээд Улсын Их Хурлын 2010 оны 27 дугаар тогтоолоор Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрээс улсын тусгай хэрэгцээнд авсан газраас зарим газрыг нь улсын тусгай хэрэгцээнээс гаргах, мөн дээрх тогтоолоор улсын тусгай хэрэгцээнд авсан зарим газрын хил заагт өөрчлөлт оруулах саналыг дэмжин Монгол улсын Засгийн газарт уламжиллаа.

Мөн тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцээд “2017 онд үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалттай хэрэглээний мод түлээ бэлтгэх хуваарь батлах тухай” аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 02 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар Шаамар сумын цэвэрлэгээний огтлолоор бэлтгэх 1000 шоо метр хэрэглээний модны төрлийг 500 шинэс гэснийг 500 нарс болгож өөрчлөв. Мөн Шаамар суманд үйлдвэрлэлийн огтлолоор хэрэглээний зориулалтаар 500 шоо метр, түлээ 100 шоо метр нарс төрлийн модыг Хүдэр сумаас, Баруунбүрэн суманд үйлдвэрлэлийн огтлолоор хэрэглээний зориулалтаар 50 шоо метр хус төрлийн модыг өөрийн нутгаас бэлтгэхээр тус тус нэмж өөрчиллөө.

-Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 97 дугаар тогтоолоор баталсан “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцээд журамд НӨАТ-ын баримт хэвлэх пос машинаар сүүлийн нэг сарын дотор үйлчилсэн 3-аас доошгүй баримт хавсаргах, Аж ахуйн нэгж нь нийт бараа бүтээгдэхүүнийхээ 10-аас доошгүй хувийг Сэлэнгэ аймагт үйлдвэрлэсэн, чанар, стандартын шаардлага хангасан бараа, бүтээгдэхүүнээр борлуулалт хийж орон нутгийн баялаг бүтээгчдийг дэмжсэн байх, Татварын байгууллагаас ямар нэг албан бичгээр сануулга, зөрчил шийдвэр аваагүй байх гэх зэрэг нэмэлт өөрчлөлтийг орууллаа.

-Сум орон нутаг, иргэдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу зөвшөөрөл олгох тухай асуудлыг хэлэлцээд Мандал сумын Түнхэл тосгонд Христийн шашны “Итгэлийн үг”

сүм байгуулж дүрмийн дагуу шашны үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгосон.

-Ой тэмдэглэх тухай асуудлыг хэлэлцээд Мандал сумын Түнхэл тосгоны "Төгөлхөн" цэцэрлэг байгуулагдсаны 50 жилийн ойг 2017 оны 07 дугаар сард, мөн сумын "Цэцэгхэн" 1 дүгээр цэцэрлэг байгуулагдсаны 50 жилийн ойг 2017 оны 10 дугаар сард, Сүхбаатар сумын Г.Бумцэндийн нэрэмжит Улсын тэргүүний 1 дүгээр сургууль байгуулагдсаны 80 жилийн ойг 2018 оны 09 дүгээр сард тус тус тэмдэглэхийг зөвшөөрлөө.

-Зарим хүмүүсийг шагналд уламжлах тухай асуудлыг хэлэлцээд нутгийн захиргаа, боловсрол, хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарт олон жил идэвх зүтгэлтэй ажиллаж эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан хүмүүсийг төрийн одон, медалиар шагнуулахаар уламжлав. Үүнд: Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 1, Алтан гадас одонгоор 5, Хөдөлмөрийн хүндэт медалиар 8 хүнийг шагнуулахаар уламжилж, Шүүхийн байгууллагад олон жил идэвх зүтгэл үр бүтээлтэй ажиллаж байгаа Сэлэнгэ аймгийн Эрүү, иргэний хэргийн шүүхийн зарим шүүгчдийг Хөдөлмөрийн хүндэт медалиар шагнуулах саналыг дэмжин Шүүхийн ерөнхий зөвлөлд уламжлав.

-Аймгийн ИТХ-ын ээлжит 5 дугаар хуралдааныг 2017 оны 05 дугаар сарын 03-ны өдөр зарлан хуралдуулахаар товыг тогтоож дараах асуудлыг хэлэлцүүлэхээр тогтлоо. Үүнд:

- 1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нийтлэг дэгийн төсөл
- 2.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаан болон Тэргүүлэгчдийн хуралдаанд асуудал оруулах, бэлтгэх, шийдвэрийг хүргүүлэх журмын төсөл
- 3.Аймгийн 2017 оны тодотгосон төсөв
- 4.Сүхбаатар сумын "Олон улсын худалдааны төв"-д худалдаа, үйлчилгээ эрхлэгчдэд талбай түрээслэх журам, үнэ тарифыг тогтоох тухай
- 5."Аймаг хөгжүүлэх сангийн журам"-д өөрчлөлт оруулах тухай
- 6."Сэлэнгэ-Энерго" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай
- 7.Тогтоолд өөрчлөлт оруулах тухай асуудлуудыг хэлэлцэнэ.

2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:

Аймгийн тариаланчдын зөвлөгөөнийг энэ сарын 24-ний өдөр Засаг даргын Тамгын газрын хурлын их танхимд зохион байгуулж, зөвлөгөөнд аймгийн удирдлагууд Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мэргэжлийн хяналтын газар, Ус, цаг уур орчны шинжилгээний албаны дарга нар болон ХХААХҮЯ-ны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Д.Есөн-эрдэнэ, Ургамал газар тариалангийн хүрээлэнгийн Газар тариалангийн секторын эрхлэгч Доктор Ж.Намбар сумдын ХАА-н тасгийн агрономич, тариаланчид нийт 150 гаруй хүн оролцож, 2017 оны зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ, технологийн талаар санал бодлоо солилцсон.

Япон улсын Шизуока мужийн Засаг даргын Тамгын газрын газар тариалангийн албаны ерөнхий мэргэжилтэн Ишикава, ахлах мэргэжилтэн Ишида, зөвлөх дарга Стимура Эрдэнэхатан, орчуулагч О.Хэрлэн нарын төлөөлөгчид тус аймагт ажиллаж, газар тариалангийн салбарт хамтран ажиллахаар байгуулсан "Санамж бичиг"-ийг хэрэгжүүлэх, гурвалжин будааг тариалах талаар санал солилцож, Зүүнбүрэн сумын нутаг дахь тариан талбайнуудаар явж бодит байдалтай танилцан, тохирох талбайг үзснээр 40 га газарт гурвалжин будаа тариалахаар боллоо.

Мөн Европын холбооны "Монгол Улсын Стандартчиллын тогтолцоог боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх" төслийн багийнхан Сэлэнгэ аймагт ажиллалаа. Багийнханы гол зорилго нь Сэлэнгийн зөгийн балыг Европын холбооны улсуудад экспортод гаргахад нь туслах, экспортод гаргах судалгааны ажлын талаар харилцан ярилцаж санал бодлоо солилцсоноос гадна аймгийн Мэргэжлийн хяналтын лаборатори, мал эмнэлэг ариун цэврийн магадлан итгэмжлэгдсэн лабораторийн болон Шаамар сумын зөгийн аж ахуй эрхлэгч зарим аж ахуйтай танилцсан. Төслийн багийнхан аймгийн Засаг даргын Тамгын газар, Хүнс, хөдөө аж

ахуйн газартай хамтран “Европын Холбооны улсуудад зөгийн бал экспортлох нь” сэдэвт семинарыг зохион байгуулж, Сүхбаатар, Зүүнбүрэн, Шаамар, Цагааннуур, Ерөө зэрэг сумдын 100 гаруй зөгийн аж ахуй эрхлэгчид хамрагдаж, Европын холбооны зөгийн балны зах зээл, гуравдагч орнууд Европын холбоонд малын гаралтай бүтээгдэхүүн экспортлоход тавигдах шаардлага, зөгийн өвчин, түүнээс сэргийлэх арга зам, эрүүл ахуйн сайн дадал ба мөшгөлт зэрэг хэрэгцээт сэдвүүдээр мэдээлэл өглөө.

Аймгийн Засаг дарга КОЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын суурин төлөөлөгч хатагтай Пак Сү Ён-ыг хүлээн авч уулзсан ба КОЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газраас аймаг орон нутгийн ажил амьдрал, хэрэгжиж буй хөтөлбөрийн үйл ажиллагаа, сайн дурын гишүүн томилох хөтөлбөрийн танилцуулгыг хийлээ. Тус байгууллагаас манай аймагт 4 сайн дурын ажилтан ажиллаж байна. Уг ажилтнууд аймгийн Биеийн тамир, спортын газар, Сүхбаатар сумын 5-р сургууль, 3, 4-р цэцэрлэг, аймгийн Эрүүл мэндийн газарт тус тус ажиллаж байна.

Бүгд Найрамдах Турк Улсын Ерөнхий сайдын дэргэдэх Туркийн хамтын ажиллагааг зохицуулах агентлаг /ТИКА/-ийн Улаанбаатар хот дахь хөтөлбөр зохицуулалтын газартай хамтран ажилласны үр дүнд тус аймгийн Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасгийн яаралтай тусламжийн нэгжийн тохижилтын ажил"-ын төслийг хэрэгжүүлэх хэлэлцээрт аймгийн Засаг дарга гарын үсэг зурлаа. Ингэснээр аймгийн Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасгийн яаралтай тусламжийн үйлчилгээг чанартай түргэн шуурхай хүргэх, хүүхдэд ээлтэй орчинг бүрдүүлэхэд онцгой чухал ач холбогдолтой арга хэмжээ боллоо.

Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссоос зохион байгуулж буй “Хүний эрхийн нээлттэй өдөр” арга хэмжээний хүрээнд Монгол улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Бямбадоржоор ахлуулсан ажлын хэсэг Сэлэнгэ аймагт энэ сарын 25, 26-ны өдрүүдэд ажиллаж аймгийн удирдлагууд болон Шүүх, Прокурор, Цагдаагийн байгууллагын удирдлагуудтай уулзаж, харилцан ярилцлаа. Ажлын хэсэг аймгийн Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба зэрэг албан байгууллагуудын ажлын нөхцөл байдалтай танилцан, хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн болон өмгөөллийн байгууллагуудтай уулзалт хийж, “Хүний эрхэд суурилсан хандлага”, “Хүний халдашгүй дархан байх эрх” сэдэвт сургалтуудыг зохион байгуулж, иргэдэд үйлчлэх чиг үүрэг бүхий өөрөө удирдах ёсны болон төрийн захиргаа, үйлчилгээний албан хаагчдын хүний эрхийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлэх, төрийн үйл ажиллагааг хүний эрхэд суурилсан арга зүйгээр хангаж, Хүний эрхийн үндэсний комиссын үйл ажиллагааг орон нутгийн иргэдэд сурталчлах, хүний эрх, эрх чөлөөний талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг үнэлэх, иргэд, олон нийт, төрийн байгууллага, албан тушаалтнуудын хүний эрхийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх зорилготой сургалт, сурталчилгаа, хяналт шалгалтын цогц арга хэмжээ, хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн талаарх мэдээллийг иргэдээс хүлээн авч шийдвэрлэх үйл ажиллагаа, хууль зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө, иргэд олон нийттэй уулзалт хийлээ.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Хүний эрхийн үндэсний комиссын Сэлэнгэ аймаг дахь төлөөлөл хамтран “Хүний эрхийн төлөө хамтдаа” аяныг эхлүүлсэн. Уг аян нь 2017 оны 04 дүгээр сарын 10-аас 12 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл зохион байгуулагдах бөгөөд НҮБ-аас “Хүний эрх”-ийн талаар гаргасан зөвлөмж, УИХ-ын тогтоол, шийдвэр, хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг Сэлэнгэ аймагт хэрэгжүүлэх арга хэмжээний 2015-2018 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, хүний эрхийн мэдлэг, хандлагыг дээшлүүлэх үндсэн зорилготойгоор байгууллага бүрт 14 хоногийн хугацаатай “Хүний эрхийн туг” аялна. Аймгийн 17 сумын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, алба, аж ахуйн нэгж байгууллага, ОНӨААТҮГ болон хууль сахиулах байгууллагууд хуваарийн дагуу хэрэгжүүлэн ажиллах ба Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газар, Шүүхийн шинжилгээний алба, аймгийн Цагдаагийн газар аяны тугийг гарын авлагын хамт хүлээн аваад байна.

Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт хамтын хэлэлцээрийг аймгийн Засаг дарга түүний Тамгын газар, аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Ажил олгогч эздийн холбоо хамтран аймгийн хэмжээнд мөрдөх хүн ам, нийгмийн хамгаалал болон хөдөлмөрийн харилцааны зарим асуудлыг иргэд, хөдөлмөрчдийн эрх ашигт нийцүүлэх зорилгоор үндсэн зарчмуудыг тохиролцож байгууллаа.

“Цэвэр орчин-Эрүүл амьдрал” аяны хүрээнд бүх нийтийн их цэвэрлэгээг 4-р сарын 22-ны өдөр аймгийн төвийн төр төсөв, аж ахуйн нэгж, иргэний нийгмийн 102 байгууллага хамрагдан хуваарийн дагуух газруудаа цэвэрлэж их хотынхоо 80 жилийн ойд бэлэг барилаа.

Аймгийн Засаг даргын 2017 оны А/165 тоот захирамжаар 2017-2019 онд хүсэлт гаргасан Хушаат, Зүүнбүрэн, Баянгол, Сүхбаатар сумдын 30 иргэнийг цэргийн дүйцүүлэх албанд элсүүлэн авч цэргийн анхан шатны сургалт бэлтгэлийг Хушаат суманд 4-р сарын 16-27-ны өдрүүдэд төвлөрүүлэн зохион байгуулсан. Сургалтын явцад тус сумын 30 жилийн ойг угтан Баржгар улаан ууланд “Хушаат 30” бичиглэлийг чулуугаар хийснээс гадна сайн үйлсийн аяны хүрээнд сумын сургуулийн биеийн тамирын талбайг тохижуулах, нэн ядуу өрхийн 5 хүүхдэд биеийн тамирын хувцас олгож, 2 айлд хүнсний бүтээгдэхүүн олголоо. Мөн 2017 оны 1-р ээлжийн цэргийн жинхэнэ албаны татлагыг 4-р сарын 28-аас эхэлсэн бөгөөд Мандал, Сайхан, Сүхбаатар сумдын цэрэг татлагын байранд бүсчлэн зохион байгуулсан. Цэргийн жинхэнэ албанд тэнцэгчдийн баримт бичгийг бүрдүүлж, анги салбарт хүргэхээр бэлтгэлийг хангаж байна.

Сэлэнгэ аймгийн төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 2017 оны 1-р улирлын тайланг Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Энэ оны 1-р улиралд нийт 5140 иргэний өргөдөл гомдлыг хүлээн авч 4753 өргөдөлд хариу өгч, 92,4 хувийн гүйцэтгэлтэй байна.

Онцгой байдлын талаар:

Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газар, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Дэлхийн зөн Монгол Олон Улсын байгууллагын Сэлэнгэ орон нутгийн хөгжлийн хөтөлбөртэй хамтран бүх сумдын байгаль орчны улсын хяналтын байцаагч, байгаль хамгаалагч, ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөлүүдийн дарга нарын сургалт, зөвлөлгөөнийг зохион байгуулж, хаврын хуурайшилт нэмэгдэж ой, хээрийн түймэр гарах эрсдэл өндөр байгаатай холбогдуулан байгаль орчны улсын хяналтын байцаагч, байгаль хамгаалагч, нөхөрлөлийн гишүүдийн ажлын хариуцлага, хяналтыг дээшлүүлэх, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, мэдээ мэдээлэл дамжуулах, бэлтгэл, бэлэн байдлыг хангах, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ болон урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх талаар үүрэг чиглэл, мэдээлэл өгсөн ба, зөвлөлгөөнд нийт 55 албан хаагч хамрагдсан.

"Өсвөрийн аврагч" тэмцээн 3 дахь жилдээ амжилттай зохион байгуулагдлаа. Аймгийн Онцгой байдлын газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллагын Сэлэнгэ орон нутгийн хөгжлийн хөтөлбөртэй 2017 онд хамтран ажиллах төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, сургуулиудын Өсвөрийн аврагч клубын үйл ажиллагааг идэвхжүүлэх, сэтгэл зүй, бие бялдарыг хөгжүүлэх зорилгоор “Өсвөрийн аврагч-2017” тэмцээнийг Сүхбаатар сумын баяр наадмын талбайд зохион явууллаа. Тэмцээнд Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 6 сургууль, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, Спортын бүрэн дунд сургууль, Алтанбулаг сумын ЕБС, Зүүнбүрэн сумын ЕБС, Шаамар сумын ЕБС, Дулаанхаан тосгоны ЕБС, Шаамар сумын МСҮТ зэрэг 13 сургуулийн баг тамирчид хурд хүч авхаалж самбаага сорин өрсөлдөж, багийн дүнгээр Сүхбаатар сум дахь Ерөнхий боловсролын 5-р сургуулийн баг тамирчид тэргүүн байр, Сүхбаатар сум дахь Ерөнхий боловсролын 2-р сургуулийн баг тамирчид дэд байр, Дулаанхаан тосгон дахь Ерөнхий боловсролын сургуулийн баг тамирчид гутгаар байр эзэлсэн амжилтуудыг тус тус үзүүллээ.

Батлагдсан удирдамжийн дагуу Алтанбулаг сумын нийт 57 объект, аж ахуйн нэгж, байгууллагуудад гамшгаас урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж 210 зөрчил илрүүлж, 28 зөрчлийг үзлэг шалгалтын явцад арилгуулж, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 36, мэдэгдэл 7, дүгнэлт 3, гал түймэр гарсан тухай акт 6-г үйлдэж байгууллагын удирдлагад өгч, хууль тогтоомж зөрчсөн, галын аюулгүй байдлын стандарт, норм, дүрмийг хэрэгжүүлээгүй, шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулаагүй, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлагын хариуг ирүүлээгүй 1 аж ахуйн нэгж байгууллагыг 250.000 төгрөгөөр, 1 иргэнийг 40.000 төгрөгөөр тус тус торгож захиргааны арга хэмжээ ногдуулсан.

Мөн “Үзвэр үйлчилгээний байгууллагууд”-д гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль, дүрэм, норм, стандартын хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөт хяналт шалгалтын удирдамжийн хүрээнд Сүхбаатар, Мандал, Баянгол, Сайхан сумдад үйл ажиллагаа явуулж буй 36 аж ахуйн нэгж байгууллагад гамшгаас хамгаалах болон гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалт зохион байгуулж 210 зөрчил илрүүлж үзлэг шалгалтын явцад 21 зөрчлийг арилгуулан бусад зөрчлийг арилгуулахаар гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 29-ийг үйлдэж байгууллагын дарга, эрхлэгч нарт хүргүүлсэн.

Мөн Онцгой байдлын газрын даргын баталсан “Алтанбулаг сумын гамшгаас хамгаалах бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах удирдамжийн хүрээнд Алтанбулаг сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа Аймгийн нэгдсэн музей, Соёлын төв, Делфин зоогийн газар, зочид буудал, Баян ундарга ХХК-ийн зоогийн газар зэрэг нийт 8 аж ахуйн нэгж байгууллагын галын аюулгүйн байдалд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулан 30 зөрчил илрүүлж, 8 зөрчлийг үзлэг шалгалтын явцад арилгуулж, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 8 бичиж байгууллагын удирдлагуудад хүргүүлсэн.

Хяналт шалгалтын ажлын харьцуулалт

Үзүүлэлт	Үзлэг шалгалтанд хамрагдсан		Зөрчил		Бичсэн эрх зүйн бичиг баримт						Хянасан зураг төсөл
	ААНБ	Айл өрх	Илрүүлсэн	Арилгуулсан	ЗБАШ	Мэдэгдэл	Танилцуулга	Дүгнэлт	Акт	АЗТогтоол	
Он											
2016 оны 04-р сар	45	-	146	19	29	19	-	2	2	-	2
2017 оны 04-р сар	57	-	210	28	36	7	1	3	6	1	-
Өссөн Буурсан /хувиар/	+21	-	+30.4	+9.5	+19.4	63	+100	+33.3	+66.6	+100	

Гамшгаас урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтын ажлын үзүүлэлтийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хяналт шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагын тоо 21 хувиар, зөрчил дутагдлыг арилгуулахаар бичсэн албан шаардлага 19.4 хувиар, илрүүлсэн зөрчил 30.4 хувиар, гал түймэр гарсан тухай акт 66.6 хувиар, дүгнэлт 50 хувиар, гал түймэр гарсан тухай акт 66.6 хувиар ажиллагаа зогсоох тогтоол +100 тус тус өссөн байна.

2017 оны 04 дүгээр сард 16 удаагийн объектын гал түймэр гарснаас 12 удаагийн гал түймэр дээр гал түймэр унтраах, аврах анги ажиллаж, 4 гал түймрийг иргэд унтраасан байна.

Гарсан ой, хээрийн болон объектын 6 гал түймрийн хэргийг Цагдаагийн байгууллагатай хамтран шалгаж, гал түймэр гарсан тухай акт 6-г үйлдэж шийдвэрлэсэн бөгөөд 3 гал түймрийн хэрэг, зөрчил хэрэг бүртгэлтийн шатанд шалгагдаж байна.

Гал түймрийн шалтгаан нөхцлийг судалж үзвэл цахилгааны ашиглалтын буруугаас 4, пийшин зуух яндангийн цонолтоос 1, ил задгай асгасан үнс нурамнаас 8, хүүхдийн болгоомжгүй үйл ажиллагаанаас 1, шалтгаан тогтоогдоогүй 2 удаа тохиолдсон байна.

Гал түймрийн нөхцөл байдлыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал:

д/д	Гал түймрийн төрөл	2016 оны 4 дүгээр сар	2017 оны 4 дүгээр сар	Өссөн, буурсан
1	Объектын	6	16	-37.5 хувиар өссөн

Орон нутгийн ус, цаг уур, орчны шинжилгээний албанаас цаг агаарын нарийвчилсан мэдээллийг авч цасан болон шороон шуурганаас урьдчилан сэргийлэх талаар факс мэдээ 2-г сум, орон нутаг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлсэнээс гадна болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх, цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан сэрэмжлүүлэх мэдээ, мэдээллийг орон нутгийн кабелийн телевизээр-1 удаа явуулсан.

Стандарт, хэмжил зүйн ажил үйлчилгээний талаар:

Алтанбулаг сумын Засаг даргын Тамгын газартай хамтран сумын худалдаа, үйлчилгээ эрхлэгчдэд стандарт, баталгаажуулалт, хэмжил зүйн үйл ажиллагааны талаар мэдлэг олгох, мэдээлэл хүргэх зорилгоор сургалт, мэдээллийн арга хэмжээ зохион байгуулж, 25 худалдаа, үйлчилгээний газрын ажилтнууд хамрагдлаа. Тус арга хэмжээний хүрээнд: “Хүнсний аюулгүй байдал, стандартчилалын өнөөгийн байдлын тухай”, “Хэмжилзүйн баталгаажуулалтын талаар”, “Зураасан код хэрхэн ашиглах тухай” сэдвүүдээр тус тус мэдээлэл өгч, 3 төрлийн 50 гаруй гарын авлага материал тараан, хэрэглэгчдээс санал асуулга авлаа.

Мөн Зүүнбүрэн сумын 3, Алтанбулаг сумын 1 хүүхэд харах үйлчилгээний газарт “Хүүхэд харах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6540:2015” стандартын дагуу тохирлын үнэлгээ хийж, зөвлөмж өгч ажиллалаа.

Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага MNS 5012:2011, Авто үйлчилгээ-Ангилал, ерөнхий шаардлага MNS 5025:2010, Автотээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ засварын тогтолцоо, тодорхойлолт MNS 4601:2011 стандартын шаардлагыг хангаж буй эсэхийг тодорхойлох зорилгоор аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Автотээврийн төв, Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга нарын хамтран баталсан удирдамжийн дагуу ажлын хэсэг Сүхбаатар сумын 8-р багт байрлах “Хүүхдийн Мөрт” ХХК, “Зэлтэрийн зам” ХХК-ийн үйл ажиллагаанд холбогдох стандартын шалгуур шаардлагын дагуу үнэлгээ хийж, дүгнэлт гарган, стандартын шаардлагыг 80-90% хангасан дээрх 2 аж ахуйн нэгжид тохирлын гэрчилгээ олголоо.

Мандал, Жавхлант, Баянгол, Сүхбаатар, Сайхан, Алтанбулаг, Түшиг сумын 8 хүнсний дэлгүүр, 1 зоогийн газар, 1 караоке бааранд холбогдох стандартын дагуу тохирлын үнэлгээ хийж тохирлын гэрчилгээ олгов.

Ээлжит баталгаажуулалтын ажлаар Хүдэр, Ерөө сум, Бугант тосгонд ажиллаж нийт 27 үйлчилгээний газарт тохирлын үнэлгээ хийснээс минимаркет-2, хүнсний дэлгүүр-3, хүнсний мухлаг-6, кофе шоп-1, караоке баар-1, дэн буудал-1 нийт 14 үйлчилгээний газарт тохирлын гэрчилгээ олгож, стандартын шаардлага хангахгүй 13

үйлчилгээний газар мэдэгдэл өгсөн. “Спирт Бал Бурам” ХХК болон Орхонтуул сумын “Саруул” ШТС-тай “Хэмжих хэрэгслийн баталгаажуулалт хийх гэрээ” байгуулж, Механик хэмжлийн ээлжит баталгаажуулалтаар Хүдэр, Ерөө сум Бугант тосгонд ажиллаж, худалдаа үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа 47 жинг баталгаажуулалтад хамруулж, иргэд, хэрэглэгч аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа 1 фазын механик 437ш, 1 фазын импульсийн 151 ш, 3 фазын механик 8ш, 3 фазын импульсийн 27ш нийт 623ш цахилгааны тоолуурыг ээлжит баталгаажуулалтанд хамрууллаа.

Стандартын салбар сангаас 11 аж ахуй нэгж, байгууллага, иргэнээс ирсэн захиалга, хүсэлтийг үндэслэн 14 аж ахуй нэгж байгууллагад, 12 нэрийн 19 стандартаар ханган, 12 аж ахуй нэгж байгууллагад 6 нэрийн 13 стандартын борлуулалт хийж, арга зүйн зөвлөгөө өгч, үйлчилгээ үзүүлсэн.

Хоёр.Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

Сангийн яамнаас өгсөн удирдамж, чиглэлийн дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны жилийн эцсийн тайлан нэгтгэн Сангийн яаманд хүргүүлж ажиллалаа.

Монгол Улсын 2017 оны төсөвт тодотгол хийгдсэнтэй холбоотойгоор аймгийн тодотгосон төсвийн төслийг боловсруулсан. Аймгийн төсвийн нийт, орлого зарлагыг 64,132.3 сая төгрөгийн тодотгох саналыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд өргөн мэдүүлсэн.

Татварын хөнгөлөлт, буцаан олголтын материал хүлээн авсан гүйцэтгэлээр нийт 2302 иргэнд 1,116.0 сая төгрөг олгохоор гарсан бөгөөд 4 дүгээр сарын байдлаар аймгийн төсвийн орлоготой уялдуулан 300.0 сая төгрөгийн татварын буцаан олголтын гүйцэтгэлтэй гарсан байна.

Аймгийн нийгэм, эдийн засгийн 2017 оны 3-р сарын танилцуулгыг боловсруулан гаргаж, аймгийн удирдлагуудад, 17 сум, 24 хэлтэс агентлагуудад хүргүүлж, танилцуулгыг www.selenge.nso.mn хуудсаар цахим хэлбэрээр мэдээлсэн.

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Орон нутгийн төсвийн нийт орлого	3,772,705.3	6,916,381.4	183.3
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	2,859,215.9	3,029,816.6	106.0
2	Орон нутгийн төсвийн нийт зарлага	19,480,318.6	17,181,188.2	88.2
	Үүнээс: ТЗШ байгууллагын зарлага	4,884,533.8	4,416,008.0	90.4
	- Аймгийн төсвийн зарлагын дүн	144,500.4	112,026.3	77.5
	- Аймгийн ОНХСангийн зарцуулалт	80,000.0	-	-
	- Аймгийн авто замын хөрөнгө оруулалт	-	-	-
	- Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	-	-	-
3	Улсын төсвөөс олгосон ОНХСангийн орлогын шилжүүлэг	293,583.1	293,583.1	100.0
4	Улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг	1,150,000.0	1,150,000.0	100.0
5	Улсын төсвөөс олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	12,143,215.5	12,143,215.5	100.0
	- Ерөнхий боловсролын сургууль	6,015,903.7	6,015,903.7	100.0
	- Хүүхдийн цэцэрлэг	3,209,503.0	3,209,503.0	100.0
	- Соёлын байгууллага	860,868.5	860,868.5	100.0
	- Биеийн тамир спортын байгууллага	334,161.2	334,161.2	100.0

	- Эрүүл мэндийн байгууллага	1,566,177.6	1,566,177.6	100.0
	- Хүүхдийн байгууллага	58,010.3	58,010.3	100.0
	- Газрын харилцааны байгууллага	98,591.2	98,591.2	100.0
6	Төсвийн байгууллагуудад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	12,143,215.5	12,143,215.5	100.0
	- Ерөнхий боловсролын сургууль	6,015,903.7	6,015,903.7	100.0
	- Хүүхдийн цэцэрлэг	3,209,503.0	3,209,503.0	100.0
	- Соёлын байгууллага	860,868.5	860,868.5	100.0
	- Биеийн тамир спортын байгууллага	334,161.2	334,161.2	100.0
	- Эрүүл мэндийн байгууллага	1,566,177.6	1,566,177.6	100.0
	- Хүүхдийн байгууллага	58,010.3	58,010.3	100.0
	- Газрын харилцааны байгууллага	98,591.2	98,591.2	100.0
7	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	894,565.6	894,565.6	100.0
8	Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	293,583.1	293,033.4	99.8
9	Аймгийн нийт ангилагдаагүй зардал	221,370.3	191,370.3	86.4
10	Үүнээс: Аймгийн Засаг даргын нөөц	157,800.0	127,800.0	81.0
11	Тусгай сангуудын зарлага	-	-	-

2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл		2017 III - сар	2017 IV- сар	<u>2017-IV</u> <u>2017-III</u> /төгрөгөөр/
1.ХҮНСНИЙ БАРАА				
1	ТАЛХ, ГУРИЛ, БУДАА			
	Гурил /савласан, кг/	1250	1250	
	Талх /орон нутгийн, ш/	1100	1100	
	Нарийн боов /кг/	2300	2500	+200
	Будаа /кг/	2400	2500	+100
	Элсэн чихэр /кг/	2200	2200	
2	МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН			
	Хонины мах /кг/	5500	6000	+500
	Үхрийн мах /кг/	6800	7000	+200
	Адууны мах /кг/	6000	6000	
	Ямааны мах /кг/	5000	5000	
	Дотор мах, цувдай /цусгүй/	5000	5000	
	Хиам /чанасан, кг/	10000	10000	
3	СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ			
	Сүү /задгай, л/	1800	1500	-300
	Сүү / савласан, л/	2500	2500	
	Тараг /задгай, л/	1800	1500	-300
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	13000	13000	
	Айраг /л/	3500	3500	
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	4000	4000	
	Өндөг /ш/	320	320	
4	БҮХ ТӨРЛИЙН ӨӨХ ТОС			
	Ургамлын тос /л/	3500	3500	
	Өөхөн тос /кг/	1800	1800	
	Шар тос /кг/	10000	10000	

	Масло /задгай, кг/	4000	4000	
5	ХҮНСНИЙ НОГОО			
	Төмс /кг/	600	600	
	Лууван /кг/	500	500	
	Манжин /кг/	1000	1000	
	Байцаа /кг/	2000	2000	
	Сонгино /кг/	2500	2000	-500
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	3200	3200	
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	2500	2500	
7	ШАТАХУУН			
	Бензин А - 80	1480	180	
	Бензин А - 92	1630	1630	
	Дизелийн түлш	1720	1720	

Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

1.Хууль эрх зүй, цагдаа, улсын бүртгэлийн талаар:

Аймгийн Засаг даргын 2017 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/141 тоот захирамжаар Захиргааны шийдвэрийг хянах хуваарь, төлөвлөгөө батлуулан хэрэгжүүлэх ажлыг эхлүүлсэн. Монгол Улсын Их Хурлаас шинээр батлагдсан хуулиудыг сурталчлах тухай ХЗДХЯ-аас өгсөн чиглэлийн дагуу сумдын Засаг дарга нарт Цагдаагийн албаны тухай, Монгол Улсын Хилийн тухай, Гэр бүлийн хүчирхийллийн тэмцэх тухай, Дотоодын цэргийн тухай, Арбитрийн тухай хуулиудын танилцуулгыг хүргүүлж, сум орон нутагтаа сурталчлах арга хэмжээ авах талаар чиглэл өгсөн. Мөн авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, аймаг, сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн дэргэд “Иргэний хяналтын зөвлөл”-ийг байгуулах саналыг аймгийн ИТХ-ын даргад хүргүүлээд байна.

Аймгийн хэмжээнд 2017 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 198 холбогдогчтой, 299.5 сая төгрөгийн хохиролтой, 171 гэмт хэрэг бүртгэгдэж, өмнөх оны мөн үетэй харьцуулбал 31 хэргээр буюу 15.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн гаралт Сүхбаатар сумын 6, 7, 8-р баг, Алтанбулаг, Хүдэр, Орхон сум, Бугант тосгонд 7.1-80,0 хувиар, Сүхбаатар сумын 1, 2-р багт 1-2 дахин өсч, Сүхбаатар сумын 4, 5-р баг, Шаамар, Ерөө, Цагааннуур, Түшиг, Хушаат, Мандал, Баянгол, Сайхан, Сант, Орхонтуул, Баруунбүрэн сумдад 12.5-66.7 хувиар, Жавхлант, Зүүнбүрэн сумдад 2-5 дахин тус тус буурч, Дулаанхаан тосгонд өнгөрсөн мөн үетэй адил түвшинд байна гэсэн тоон үзүүлэлттэй байна.

Улсын бүртгэлийн үйлчилгээнд 2017 оны 4 дүгээр сард 215 төрөлт, 63 гэрлэлт, 13 гэрлэлт цуцлалт, 51 нас баралт бүртгэгдэж, 382 иргэнд цахим үнэмлэх, 77 иргэнд үндэсний энгийн гадаад паспорт, ОХУ-ын хавсралт 4811 ширхэг олгож, аймаг, хотруу шилжин явсан 237, шилжин ирсэн 423, сум дүүрэгт шилжин ирсэн 109, сум дүүрэгт шилжин явсан 96, баг хооронд шилжин ирсэн 379, баг хооронд шилжин явсан 366 шилжилт хөдөлгөөн бүртгэгдээд байна. Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлд 962 бүртгэл, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын 1319 бүртгэл бүртгэгдэж, улсын тэмдэгтийн хураамж 156535 төгрөг, үйлчилгээний хураамж 15.635.748 төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны татвар 8.768.000 төгрөгийг тус тус төвлөрүүлээд байна.

2.Архивын талаар

Дархан-Уул аймагт энэ сарын 28, 29-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Монгол Улсад орчин цагийн Архивын салбар үүсэн байгуулагдсаны 90 жилийн ойг угтсан “Төвийн бүс”-ийн урлаг, спорт, ажил мэргэжлийн тэмцээн, уралдаанд аймгийн төр, төсвийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан 18 ажилтан оролцож багаараа 2-р байр эзэлсэн амжилт үзүүллээ.

Архивын тасгийн нөхөн бүрдүүлэлтийн төлөвлөгөө, хуваарийн дагуу Сайхан сумын Номгон тосгоны Захирагчийн албаны 2000-2016 оны 20 хадгаламжийн нэгж, ЕББДС-ийн 1978-2016 оны 43 хадгаламжийн нэгж, 28-р цэцэрлэгийн 1983-2016 оны 79 хадгаламжийн нэгж, Соёлын төвийн 2008-2016 оны 39 хадгаламжийн нэгж, ЭМТ-ийн 1995-2016 оны 42 хадгаламжийн нэгж, нийт 5 төр, төсвийн байгууллагын 223 хадгаламжийн нэгжийг жагсаалтын дагуу хүлээн авч шинээр хөмрөг үүсгэн хувийн хэргийн бүрдлийг хангаж ажилласан. Мөн дээрх төр төсвийн байгууллагуудын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнуудад “Баримт бичгийн стандарт” сэдэвт сургалт зохион байгуулж хадгаламжийн нэгж бүрдүүлэх, баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх тухай заавар зөвлөгөө өгч ажилласан.

Баримтыг цахимд шилжүүлэх ажлын хүрээнд Номгон тосгоны Захирагчийн албаны 2000-2016 оны 20 хадгаламжийн нэгж, Соёлын төвийн 2008-2016 оны 39 хадгаламжийн нэгж, ЕББДС-ийн 1978-2016 оны 43 хадгаламжийн нэгж, ЭМТ-ийн 1995-2016 оны 42 хадгаламжийн нэгж, 28-р цэцэрлэгийн 1983-2016 оны нийт 5 хөмрөгийн 119 хадгаламжийн нэгжний 25369 хуудасны мэдээллийн агуулгыг уншиж заалт-23453, хүний нэр-72666, байгууллагын нэр-3463, газар зүйн нэр-5135-ийг АМС программд шивж, эх баримттай нь холбох ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн Ерөөгийн мод бэлтгэлийн аж ахуйн нийт 8 хадгаламжийн нэгжийн 732 хуудас баримтыг цахим хэлбэрт шилжүүлсэн. Мөн Сайхан сумын Номгон тосгоны Захирагчийн албаны 20 хадгаламжийн нэгж, Соёлын төвийн 39 хадгаламжийн нэгж, ЕББДС-ийн 43 хадгаламжийн нэгж, ЭМТ-ийн 42 хадгаламжийн нэгж, 28-р цэцэрлэгийн 79 хадгаламжийн нэгж, нийт 119 хадгаламжийн нэгжийн 6339 хуудас баримтыг скайнердаж мастер хувь үүсгэсэн.

Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

1.Боловсрол, соёл урлаг, спортын чиглэлээр:

Ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагчдын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг төрөлжсөн хичээлийн олимпиадыг “Улсын төрөлжсөн олимпиад зохион байгуулах нийтлэг журам”-ын дагуу БСШУСЯ-аас ирүүлсэн хуваариар 13 чиглэл, 50 ангиллаар, 509 багш, 825 сурагчийг оролцуулан зохион байгуулж, аймгийн аварга, багш сурагчийг шалгаруулан, тайланг БСШУСЯ-нд хүргүүлсэн.

Хараа бүсийн сургууль, цэцэрлэг, соёл, урлагийн байгууллагуудад зөвлөн туслах чиглэлээр ажиллаж, бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын төлөвлөгөөний хэрэгжилт, анги дүүргэлт, багшийн хүрэлцээ хангамж, сонгон гүнзгийрүүлж судлах хичээлийн төлөвлөлт, хэрэгжилт, сургалтын орчны тохижилт, засвар үйлчилгээ, эрүүл ахуй, хүүхэд бүрийг хөгжүүлэх, төлөвшүүлэх чиглэлээр зохион байгуулж байгаа ажил, түүний үр дүн, сурагчийн дүрэмт хувцас, сурах бичгээр хангагдсан байдал, хүрэлцээ хангамж, сурах бичиг худалдан авалт, номын сан, дотуур байр, сургууль, цэцэрлэгийн гал тогоо, үдийн цай, хөрөнгө оруулалт, төсөв, санхүүгийн үйл ажиллагааг тусгай удирдамжийн дагуу газар дээр нь үзэж танилцаж, 216 цагийн хичээл, үйл ажиллагааг ажиглан, 376 багш, ажилтанд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Аймгийн боловсролын салбарын удирдах ажилтнуудыг чадавхжуулах, туршлага судлах, эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг Улаанбаатар хотод зохион байгуулж, сургуулийн захирал, цэцэрлэгийг эрхлэгч, БСУГ-ын мэргэжилтэн зэрэг нийт 78 хүн оролцож, “Суурь, бүрэн дунд боловсролын бодлого, чиг хандлага, хэрэгжиж буй төсөл хөтөлбөр”-ийн мэдээлэл, “Хөдөлмөрийн харилцааны эрх зүй”, “Хөдөлмөрийн эрх зүйн акт боловсруулах дадлага ажил”, “Хуулийн зөвлөх үйлчилгээ”, “Харилцааны урлаг”, “Байгууллагын менежмент, удирдлагын манлайлал”, “Байгууллагын төсөв зохиох арга зүй”, “Төсөл боловсруулах арга зүй”, “Байгууллагын стратегийн бодлого төлөвлөлтийн арга зүй”, “Сургалтын үнэлгээг боловсронгуй болгож шинэчилэх нь”, “Харилцааны урлаг” сэдвүүдээр сургалтанд хамрагдаж, ХСҮТ-ийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдлаа.

Боловсролын үнэлгээний төвөөс жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг боловсролын чанарын үнэлгээний шалгалтыг 2017 оны 04 дүгээр сарын 17-20-ны өдрүүдэд Сүхбаатар сумын 1, 2 дугаар сургууль, Ерөө сумын сургуулийн 5,9,12 дугаар ангийн давхардсан тоогоор 1300 гаруй сурагчаас монгол хэл, математик, гадаад хэл, сонгох хичээл зэрэг агуулгуудаар шалгалтыг авч, материалыг хүргүүллээ.

Монгол Улсын Засгийн газрын “Монгол хэлбичгийн боловсролыг сайжруулах арга хэмжээний тухай” 2013 оны 37 дугаар тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны А/309 дүгээр тушаалаар баталсан “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон боловсролын чанарын үнэлгээний журам”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 12 дугаар анги төгсөгчдөөс авах монгол хэлбичгийн хичээлийн төгсөлтийн болон элсэлтийн шалгалтад бэлтгэх бэлтгэл ажлыг бүрэн хангуулах, багш нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Нийслэлийн 11 дүгээр сургуулийн зөвлөх багш, үндэсний сургагч, суурь, бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөр боловсруулах багийн гишүүн Ц.Март “Монгол хэлбичгийн хичээлээр хүүхэд бүрийг хөгжүүлэх арга зүй” сургалт семинарыг 2017 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр Сүхбаатар сумын Улсын тэргүүний 1 дүгээр сургууль дээр зохион байгууллаа. Сургалтад Монгол хэлбичиг, уран зохиолын багш 50 хүн хамрагдаж, мэдлэг, ур чадвараа дээшлүүлэн ажиллалаа.

2016-2017 оны хичээлийн жилд суурь, бүрэн дунд боловсрол эзэмшигчдийн гэрчилгээ, үнэмлэхний захиалгыг Ерөнхий боловсролын сургууль болон боловсролын баазтай тулгалт хийн, захиалгын хүсэлтийг БСШУСЯ-нд албан бичгийн хамт хүргүүлсэн. 2016-2017 оны хичээлийн жилд суурь боловсрол эзэмших 1333, бүрэн дунд боловсрол эзэмших 1521 сурагч нийт 2854 сурагчдын гэрчилгээ үнэмлэхний захиалга хийгдээд байна.

Сэлэнгэ аймагт ЭЕШ өгөх сурагчдын бүртгэлийг урьдчилсан байдлаар нэгтгэн Боловсрол, Соёл, Урлагийн газарт бүртгүүлсэн 1484 шалгуулагчийн баазыг Боловсролын үнэлгээний төвд хүлээлгэн өглөө.

Монгол Улсын Засгийн газар болон Япон улсын Засгийн газрын хооронд байгуулсан гэрээ хэлэлцээрийн дагуу БСШУСЯ-ны дэргэдэх “Инженер технологийн дээд боловсрол” төслөөс зохион байгуулж буй 2017-2018 оны хичээлийн жилд Япон улсад суралцуулах суралцагчдийн элсэлтийн урьдчилсан шалгаруулалтын бүртгэлийг хийж, нийт 119 сурагч бүртгүүлсэн ба урьдчилсан шалгалтыг Сүхбаатар сумын 2 дугаар сургууль дээр зохион байгууллаа. Шалгалтыг төслийн хэрэгжүүлэгч байгууллага ШУТИС-ийн дархан салбар дахь сургуулийн багш нартай хамтран амжилттай зохион байгууллаа.

Сүхбаатар сумын 3, 6 дугаар сургуулийн захирал, Зүүнбүрэн, Мандал сумын Мишээл, Шаамар сумын 2, Баруунбүрэн, Ерөө, Хушаат, Сүхбаатар сумын сувиллын ясли, Номгон тосгоны цэцэрлэгийн эрхлэгчийн ажлын байранд Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 60 дугаар тогтоолын дагуу “Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын дагуу сонгон шалгаруулалт явуулж, сонгон шалгаруулалтад оролцсон 21 иргэнээс 7 иргэн хангалттай үнэлгээ авч тэнцлээ.

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн дотуур байрны багш нарын сургалт хариуцсан арга зүйч Болормаатай хамтран Улсын тэргүүний Баянгол сумын Улсын тэргүүний ерөнхий боловсролын сургууль дээр “Дотуур байрны багш нарт мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж чадваржуулах нь” сэдэвт сургалтыг 19 дотуур байрны 30 багшийг оролцуулан зохион байгуулж, батламжийг гардуулсан.

БОАЖЯ, БСШУСЯ, Швейцарын хөгжлийн агентлаг, Байгаль орчны мэдээл сургалтын төвөөс хамтран 2017.04.21-22-нд зохион байгуулсан “ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИГЧ ЭКО СУРГУУЛЬ” сэдэвт Олон улсын эко сургууль хөтөлбөрийн сүлжээнд шинээр элсэж буй сургуулиудын багш, сурагчид болон сургуулийн удирдлагад зориулсан анхан шатны 1-р сургалтын хөтөлбөрт Шаамар сумын ЕБС, Хөтөл ЕБС, Сүхбаатар сумын 1, 4-р сургуулиудын нийт 40 багш, сурагч, удирдлага хамрагдсанаар сургагч багш болох эхлэл тавигдан, тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санаанд суурилсан олон улсын эко сургууль хөтөлбөрийн үзэл

баримтлал, аргачлалыг сургуулийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд тусгах, “Сургуулийн орчин” сэдвийн хүрээлэн буй орчны үнэлгээний арга зүйгээс суралцлаа.

МУБИС-ийн Багшийн сургуулийн математикийн тэнхмийн багш, профессор Б.Магсар багштай хамтран “Бага ангийн багш нарын заавал бодох өгүүлбэртэй 500 бодлогыг бодох аргачлал” сэдэвт захиалгат сургалт зохион байгуулж, нийт бага ангийн 192 багшийг хамруулсан. Тус сургалтаар багш нар өгүүлбэртэй бодлогыг олон аргаар бодож болдог, хүүхдээр бодуулж сургах ямар алхмууд хийх талаар арга зүйг зааж, өөрсдөөр нь бодлого бодуулж сорьсон үр дүнтэй сургалт болсон. Мөн цаашид дээрх багштай холбогдож багш нар хамтран даалгаврын сан боловсруулах, бодлогын түүвэр хийх талаар сургууль дээрээ сургалт авахаар харилцан санал солилцсон.

Сэтгэх чадварын 15 дахь удаагийн улсын олимпиадын 2-ын давааг жил бүр уламжлал болгон Сүхбаатар сумын Улсын тэргүүний 2-р сургуулийн дэргэдэх IQ клубтэй хамтран бага ангийн сургалтын менежер С.Азей багшийн нэрэмжит болгон явуулж байгаа бөгөөд түүний гэр бүл шагналыг ивээн тэтгэж амжилттай зохион байгууллаа. Тус олимпиадын 6 ангилалд нийт 177 сурагч, “Бүтээлч сэтгэдэг багш” бүтээлийн уралдаанд 13 багш оролцсоноос, дараагийн шатны олимпиадад 10-11 дүгээр ангийн ангилалд Хөтөл ерөнхий боловсролын сургуулийн 11 дүгээр ангийн сурагч Ю.Мөнхтунгалаг, 12 дугаар ангийн ангилалд Түшиг сумын сургуулийн 12а ангийн сурагч Т.Соёл-Эрдэнэ, Сүхбаатар сумын Улсын тэргүүний 4-р сургуулийн бага ангийн багш С.Цэндээ нар оролцохоор шалгарлаа.

Сургууль бүрт Боловсролын чанарын шинэчлэл төслийн “Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөр”-ийн 3 дахь шатны төслийн санал бичих үйл ажиллагаа явагдаж, сургууль бүрээс ирүүлсэн төслийн саналыг уншиж танилцан, дахин сайжруулалт хийлгэж, нийт төрийн хэвшлийн 31 сургуулийн саналыг БСШУСЯ-ны дэргэдэх “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн албанд хүргүүллээ.

БСШУСЯ-аас зохион байгуулсан “Тогтвортой хөгжлийн боловсрол”-ийн үзэл санааг хэрэгжүүлэх зорилготой сургуулийн багш нарыг чадавхжуулах сургалтанд Сэлэнгэ аймгийн 54, Говьсүмбэр аймгийн 15, Төв аймгийн 48 нийт 114 хүн оролцож, Сэлэнгэ аймгийн сургалтанд оролцсон багш нар бусад өөрийн болон сургуулийн багш нарт сургалт зохион байгуулан тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санааг түгээн дэлгэрүүллээ.

“Боловсролын чанарын шинэчлэл” төслийн нэгдүгээр зорилтод бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд төрийн өмчийн сургуулийн бага ангиудад Математик, байгалийн ухаан, технологийн хичээлийг интеграцчилан бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх зорилго бүхий “STEAM” боловсролын сургалтын багц хэрэглэгдэхүүн нийлүүлэгдэж эхлээд байна. Манай аймагт нийт 174 сая 979 мянган төгрөгийн санхүүжилт бүхий 3 төрлийн 711 багц хэрэглэгдэхүүн нийлүүлэгдэнэ. “STEAM” боловсролын сургалтын багц хэрэглэгдэхүүнийг хэрхэн ашиглах арга зүйд багш нарыг сургах сургалтыг 2017 оны 6 дугаар сарын 10-аас эхлэн зохион байгуулахаар төлөвлөж, 04 дүгээр сарын 24-28-ны өдрүүдэд Улаанбаатар хотод сургагч багш бэлтгэх сургалт явагдаж, БСУГ-ын мэргэжилтэн Т.Сундуй, П.Мягмарсүрэн, Сүхбаатар сумын УТ-ий лаборатори 4 дүгээр сургуулийн бага ангийн сургалтын менежер Л.Оюунтүлхүүр нар сургалтанд хамрагдаж байна.

Хөнгөн атлетикийн өсвөрийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн 4-р сарын 15-16 ны өдрүүдэд зохион байгуулагдлаа.Тэмцээнд Баянгол, Зүүнхараа, Хэрх 4-р сургууль, Цагаануур, Зүүнбүрэн, Алтанбулаг, Шаамар, Дулаанхаан, Спорт, СБ-2, СБ-3, СБ-5, СБ-6-р сургуулийн нийт 186 өсвөрийн тамирчид ололцлоо .Бага нас (15-16)100м, 200м, 400м, 800м, 1500м, 3000м, Ахлах (17-18) нас 100м, 200м, 400м, 800м, 1500м 5000м, уртын харайлт гэсэн төрлүүдээр аврагуудаа шалгарууллаа.

2.Хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний талаар:

2017 оны 03-р сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэд 889 байсан бол 74 иргэн шинээр бүртгүүлж ажил олгогчоос ирүүлсэн 35 ажлын байранд 32 хүнийг

ажилд зуучилж, идэвхигүйн улмаас 84 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 847 болсон байна.

“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян-2017” арга хэмжээний нээлтийг 4 дүгээр сарын 05-ны өдөр зохион байгуулж, 35 аж ахуй нэгж байгууллагын 320 гаруй ажилтан албан хаагчид оролцож “Эрүүл аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага”-аар “Урсгал ус” ХХК-г шалгаруулан шагнаж урамшууллаа.

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 404 дүгээр тогтоол, 2016 оны 58 дугаар тэмдэглэл, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/09 тоот тушаал, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны А/09 тоот тушаалын хэрэгжилтийн хүрээнд 98 тоологч, 16 шивэгч, 56 хөтөч, 34 жолооч болон багийн ахлагч, дотоод хяналтын баг, чиглүүлэгчийн бүрэлдэхүүнтэйгээр Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааны ажлыг зохион байгууллаа. Аймгийн хэмжээнд судалгаанд 20162 өрхийн жагсаалт үүсэж үүнээс 20051 өрхийг судалгаанд хамруулж, 110 өрх татгалзсан төлөвтэй байна.

Нийгмийн халамжийн сангаас 4-р сарын байдлаар 25349 иргэнд 3,654,075,562 төгрөгийг олгоод байна. Үүнд:

- Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2414 иргэнд 1,244,007,640 төгрөг
- Нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмж 1246 иргэнд 291,616,050 төгрөг
- Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж 1154 иргэнд 230,867,340
- Ахмад настны тусламж, хөнгөлөлт 2414 иргэнд 107,772,990 төгрөг
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгож буй тусламж хөнгөлөлт 160 иргэнд 31,259,024 төгрөг
- Жирэмсэн, хөхүүл нярай хүүхэдтэй 2544 эхэд 307,908,020 төгрөг
- Алдар цолтой ахмад настанд үзүүлэх тусламж хөнгөлөлт 54 иргэнд 22,476,670 төгрөг
- Эхийн алдар одонтой эхчүүдийн хөнгөлөлт тусламжинд 7807 иргэнд 1,048,520,000 төгрөг
- Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ 3715 иргэнд 83,244,498 төгрөг
- Насны хишиг 3895 иргэнд 309,060,000 төгрөг

3. Эрүүл мэндийн талаар

2017 оны 3-р сарын байдлаар 392 эх төрж, 392 хүүхэд мэндэлсэн. Мөн нас баралт 125 бүртгэгдсэнээс хоног болоогүй 5 нас баралт бүртгэгдсэн байна. Үүнээс 0-1 насны хүүхдийн эндэгдэл 2, өмнөх үеийн мөн үеэс 15 тохиолдлоор, 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 2 өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор буурсан, эхийн эндэгдлийн тохиолдол гараагүй байна.

2017 оны 3-р сарын байдлаар артерийн гипертензи, чихрийн шижин хэд шинж 2-ийн эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт 27,4%-тай байна. Хөх, умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэг 14,8%-тай байна.

Шинээр хяналтанд хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдийн судалгааг авч нэгтгэлээ. Нийт 236 жирэмсэн хяналтанд хамрагдсанаас 185 жирэмсэн эмэгтэй эхний 3 сартайд 51 жирэмсэн эмэгтэй хожуу хяналтанд хамрагдлаа.

Төлөвлөгөөний дагуу менингит өвчнөөс урьдчилан сэргийлэх хамар, залгиурын үзлэгийг нийт 7510 хүүхдийг хамруулж, үрэвсэлтэй илэрсэн 760 хүүхдийг эрүүлжүүлэх ажлыг эхлүүлсэн.

Дэлхийн эмч нарын өдрийг угтаж аймгийн эрүүл мэндийн салбарын эмч нарын дунд “Авьяаслаг эмч” сэдэвт урлаг, спортын арга хэмжээнүүдийг зохион байгуулж, тэмцээнд нийт 10 багийн 100 тамирчин хурд, хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдөж аймгийн нэгдсэн эмнэлгийн “DOCTORS” баг тэргүүн байр, Эрүүл мэндийн газрын “ТИТЭМ” баг 2-р байранд, Мандал сумын нэгдсэн эмнэлгийн “STARS”, Ерөө бүсийн EVOLUTION баг гутгаар байранд тус шалгарсан.

Сүрьеэтэй тэмцэх, сэргийлэх, сүрьеэгийн өвчлөл тархалтын өнөөгийн байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, цаашдын зорилтын талаарх тайланг баримтат кино хэлбэрээр хийж Монголын сумын эмч, мэргэжилтнүүдийн холбоонд, нутаг 21 ТВ, Таны Сэлэнгэ ТВ, цахим орчноор мэдээллийг түгээж ард иргэдэд сургалт сурталчилгааг хийлээ.

4.Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар:

“Уран жиргээ -2017” уран уншлагын аймгийн наадмыг Дэлхийн зөн Монгол ОУБ-ын Сэлэнгэ орон нутгийн хөтөлбөртэй хамтран зохион байгуулж, 14 сумын 70 гаруй сурагчид 4 насны ангиллаар оролцож насны ангилал тус бүрт шалгарсан сурагчдыг “Уран жиргээ” улсын уралдаанд оролцуулсан ба 6-9 дүгээр ангийн ангилалд Э.Энхсүлд хүрэл медаль хүртлээ.

Мөн Бэлчир бүсийн Ерөнхий боловсролын сургуулиудын дунд “Спорт өрөлт” тэмцээнийг Дэлхийн зөн Монгол ОУБ-ын Сэлэнгэ ОНХ Хөтөлбөр, Сүхбаатар сумын Улсын тэргүүний 4 дүгээр сургуультай хамтран зохион байгууллаа.Тэмцээнд 92 сурагчид 5 насны ангилалд оролцож шалгарсан сурагчдад өргөмжлөл, медаль гардууллаа.

Хүүхэд харах үйлчилгээг 10 төвд 32 иргэн эрхэлж, нийт 157 хүүхэд хамрагдснаас хөгжлийн бэрхшээлтэй 3 хүүхэд байна.Энэхүү үйлчилгээнд санхүүгийн дэмжлэг олгох журмын дагуу хүүхдийн давхардал, нийгмийн даатгалд хамрагдаж байгаа байдалд судалгаа хийж, сар бүрийн явцын тайланг дээд шатны байгууллагад тайлагнан ажиллаж байна.

“Өсвөр үеийнхний нөхөн үржихүйн эрүүл мэнд” сургалтыг “Наран сэтгэл” ТББ-тай хамтран Ерөнхий боловсролын 34 сургуулийн нийгмийн ажилтнуудыг хамруулан зохион байгууллаа. Мөн хурдан морины уралдаанч хүүхдийн эрх, амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалахад тулгамдаж буй асуудлаар “Хурдан морины уралдаанч хүүхдийн аюулгүй байдал, хүүхэд хамгаалал” зөвлөгөөнийг 04-р сарын 07-ны өдөр зохион байгуулж, 6 сумын нийт 50 төлөөлөгч оролцон, гурвалсан гэрээний төслийг хэлэлцэн саналаа орууллаа.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хамтын ажиллагааг эрчимжүүлэх үүднээс сэтгэл зүйчдийн “Кофе уулзалт” хийсэн. “Хамтарсан багаар хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх нь” сургалтыг зохион байгуулж 120 хүн хамрууллаа.

Хүүхдийн тусламжийн 108 утаснаас ирсэн мэдээллийн дагуу 10 хүүхэд, 7 иргэнд хариу үйлчилгээ үзүүллээ.

5.Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ажил үйлчилгээний талаар

Аймгийн хэмжээнд Нийгмийн даатгалын сангуудад 8772214,86 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл оруулах төлөвлөгөөтэйгээс 8703475.29 сая төгрөг хуримтлуулж төлөвлөгөөний биелэлт 99,2 хувьтай байна.

Тэтгэврийн даатгалын сангаас 15489 тэтгэвэр авагчдад 17925.22 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын сангаас 2241 хүнд 714.32 сая төгрөгийг хөдөлмөрийн чалдвар түр алдсан болон оршуулгын тэтгэмжид, эрүүл мэндийн даатгалын сангаас эмнэлэг, эмийн сангуудад 1385.77 сая төгрөгийн зардлыг, ажилгүйдлийн даатгалын сангаас 190 даатгуулагчид 259.00 сая төгрөгийг олгосон. Мөн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас 250 даатгуулагчид 363.32 сая төгрөгийг тэтгэвэр, үйлдвэрлэлийн ослын тэтгэмж, сувиллын зардалд олгосон байна.

2017 оны 04 дүгээр сард 143 хүн сайн дурын даатгалд хамрагдлаа.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс 2 удаа хуралдаж, шинээр 3 иргэн тогтоож, сунгалтаар 356 иргэн, 11 иргэний 11 иргэний актыг цуцалсан, шилжсэн 3, эрх үүсэхгүй 4 иргэний материалыг хэлэлцсэн.

Сүхбаатар сумын ажил олгогч, даатгуулагч иргэдэд нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомжийг сурталчилан таниулах ач холбогдлыг ойлгуулах зорилгоор 9 аж ахуйн нэгжийн нийт 150 гаруй даатгуулагчдад сургалт хийж, иргэд даатгуулагчдаас 21 өргөдөл ирсний 11 өргөдлийг бүрэн шийдвэрлэсэн, 10 өргөдөл шийдвэрлэх шатандаа байна.

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой 7 байгууллагыг шүүхэд шилжүүлснээр, дээрх байгууллагууд нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрснөөр нийгмийн даатгалын өр авлагыг төлөх хуваарь гарган барагдуулан ажиллаж байна.

Тав.Үйлдвэр, хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:

Аймгийн хэмжээнд 733341 толгой эх мал төллөхөөс 04 дүгээр сарын 24-ний өдрийн байдлаар 327172 толгой эх мал төллөсөн. Үүнээс ингэ-36, гүү-2443, Үхэр-21099, эм хонь 182047, эм ямаа 121547, нийт мал төллөлт 44.6 хувьтай, төл бойжилт 97.5 хувьтай байна.Төл малын зүй бус хорогдол 8259, том малын зүй бус хорогдол 38572 толгой мал хорогдож нийт малын 2.4 хувийг эзэлж байна.

Алтанбулаг, Зүүнбүрэн, Түшиг, Шаамар сумдаас ирсэн өвчилсөн, хорогдсон мал, амьтны 65 эмгэгт дээжинд стандарт арга зүйн дагуу оношлогоо шинжилгээг хийж, УМЭАЦТЛ-иор баталгаажуулан хариуг маягтын дагуу гарган авч холбогдох мал эмнэлгийн нэгж болон иргэдэд өгсөн бөгөөд халдварт өвчний үүсгэгч илрээгүй болно. Ийлдэс судлалын шинжилгээнд Сүхбаатар сумаас 18 адуунд нийлүүлгийн өвчин, ям, адууны халдварт цус багадах өвчин, Зүүнбүрэн сумын 18 буханд бруцеллез, лейкоз, сүрьеэ нийт давхардсан тоогоор 126 дээжинд шинжилгээ хийж эрүүл болохыг баталгаажуулж хариуг хүргүүлсэн. Мөн аймгийн төвд худалдан борлуулагдаж буй төв нийтийн хоолны газарт нийлүүлэгдэж байгаа мал, аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний адууны махны 5 дээж, 615 кг, үхрийн махны 52 дээж 1196 кг, хонины махны 32 дээж 4064 кг, ямааны махны 6 дээж 123 кг, гахай 3 дээж 291 кг, сүүний 112 дээж 3360 л, дайвар 7 дээж 210 кг, өндөгний 12 дээж 7200 ш дээжинд тус тус Мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээг хийж баталгаажуулж гэрчилгээ олголоо.

Нэг эрүүл мэнд Д43 төслийн гэдэсний эгэл биетнээр үүсгэгддэг зоонозын халдварын экологи эпидемиологи судалгааны ажлын хүрээнд Цагааннуур сумын 25 өрхийн хүн малын ундны усны - 27 дээж, зэрлэг амьтан хүн малын ялгадаснаас -127 дээж авч гэдэсний эгэл биетнээр үүсгэгддэг зоонозын халдварын талаар урьдчилан сэргийлэх сургалт, мэдээлэл сурталчилгааг хийж 75 малчин өрхийг хамрууллаа.

“Органик хүнсний тухай хууль”-ийг дагалдан гарах 7 журам, 1 аргачлалын төслийг хэлэлцэх хэлэлцүүлгийг аймгийн төвд зохион байгуулж, Шаамар, Сүхбаатар, Алтанбулаг сумдын Хүнс, хөдөө аж ахуйн салбарын үе үеийн 40 гаруй хүний төлөөллийг оролцуулсан.Хэлэлцүүлгээс гарсан саналыг нэгтгэн Хүнс, хөдөө аж ахуйн яаманд хүргүүлээд байна.

Зургаа. Хөрөнгө оруулалт, газрын харилцааны хүрээнд:

1.Хөрөнгө оруулалт, газрын харилцаа, барилга хот байгуулалтын талаар:

Цахим худалдан авах ажиллагааны систем /www.tender.gov.mn/ сайтад мэдээлэл байршуулах талаарх зөвлөгөөг сумдын холбогдох мэргэжилтнүүдэд өгч, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд засвар оруулах тутамд хянан шалгаж Сангийн яаманд уламжлан баталгаажуулж байна.

Худалдан авах ажиллагааны АЗ сертификат олгох сургалтыг аймгийн Засаг даргын Тамгын газрын их танхимд 4-р сарын 18-аас 20-ны өдрүүдэд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Сангийн яамны холбогдох мэргэжилтнүүд зохион байгуулж 100 хүн хамрагдсанаас 48 хүн тэнцсэн.

2.Байгаль орчны талаар:

Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор сумдын байгаль хамгаалагч нартай Түймрийн хариуцлагын гэрээ байгуулсан.

“Бүх нийтээр мод тарих ажлыг Сүхбаатар сумын хэмжээнд зохион байгуулах, арчлан хамгаалах, хашаажуулах” ажлын техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, зургийг боловсруулан Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэн тендерийн ажлыг хамтран зохион байгуулж байна. “Бүх нийтээр мод тарих өдөр”-ийг хавар, намар 2 удаа зохион байгуулах ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас сум, тосгон бүрт 1000,000 төгрөгийг олгохоор албан тоот хүргүүлсэн.

Хог хаягдлын талаар цогц ойлголт олгох зорилгоор сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад зөв дадал

төлөвшүүлэх сургалтыг ерөнхий боловсролын сургуулиудын “Лидер сурагч- клубтэй хамтран зохион байгуулалаа. Сургалтанд 50 гаруй сурагч хамрагдав.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдэх ойжуулалтын ажлын тендерийг зохион байгуулахад “Ойн хүрэм” ХХК, “Өргөн сэлэнгэ” ХХК материал ирүүлсэн бөгөөд тендерийн баримт материалыг хянан шалгах ажиллагаа хийгдэж байна.

Долоо.Сум орон нутгийн талаар:

Алтанбулаг сум:

Аймгийн Онцгой байдлын газраас сумын Онцгой комисс болон мэргэжлийн ангийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд сургаж, дадлагажуулах, эрсдэл, эмзэг байдлыг бууруулах, ой хээрийн түймэр, усны осол, хүчтэй салхи шуурга, хүн, мал амьтны гоц халдварт өвчин гарсан тохиолдолд шуурхай хариу арга хэмжээ авах, холбогдох газартай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, иргэдийг татан оролцуулах, хор уршгийг арилгах арга ажиллагаанд сургах, дадлагажуулах зорилгоор 04 дүгээр сарын 10-ны өдөр сумын гамшгаас хамгаалах штаб, албад мэргэжлийн ангиудын бэлтгэл бэлэн байдлыг шалгаж, сургалт, зөвлөн туслах арга хэмжээг зохион байгууллаа. Уг сургалтаар Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн дүрэм, Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах, Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах журмын талаар аймгийн сургалт хийж, сумын онцгой комисс болон штабын орон тооны бус зөвлөлийнхөнд цагийн байдал өгч дадлага сургууль явуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Аймгийн Засаг даргын захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор Бүх нийтийн хог цэвэрлэгээний ажлыг зохион байгуулж, төрийн байгууллагууд хуваарьт хэсгүүдээ цэвэрлэж, иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд байгууллагынхаа ойр орчим 50 метр газрыг цэвэрлэлээ.

Аймгийн мэргэжлийн хяналтын газраас тус суманд төлөвлөгөөт болон тандалтын хяналт шалгалтыг 04 дүгээр сарын 14-ний өдөр хийж, шалгалтаар согтууруулах ундааны тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүд, чөлөөт бүсийн архи, согтууруулах ундаа худалдан борлуулдаг дэлгүүрүүдээр орж тусгай зөвшөөрөл болон шинжилгээний бичгийг шалгаж, зөвлөгөө өглөө. Мөн ЕБС-ын дотуур байр, үдийн цай, “Дамбо”, “Найрамдал” цэцэрлэгүүдийн гал тогоо, ажилчдын эрүүл ахуй, хоол хүнсний чанар, аюулгүй байдал, хоолны цэс, дээж авах, устгах болон ариутгал цэвэрлэгээний бүртгэл хөтлөлтийг шалгаж, зөвлөгөө мэдээллийг өгч ажиллалаа.

“Эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн бүс болгох тухай” хэлэлцүүлэг 04 дугаар сарын 19-нд зохион байгуулагдлаа. Энэхүү хэлэлцүүлгээр Алтанбулаг сумын бэлчээрийн талбай, даац, малын тоо толгойг багасгаж чанаржуулах, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх, бүс тогтоох талаар хэлэлцүүлэгт оролцсон сумын удирдлагууд болон газар тариалан эрхлэгчид, ногоочдын төлөөллүүд, малчдын төлөөллүүд санал бодлоо солилцож, хүсэлтээ уламжилсан.

Сумын 3-р багт орших Бөхлөө хангайд энэ сарын 12-ны шөнө түймэр гарлаа гэсэн дуудлагын дагуу Байгаль орчны хяналтын Улсын байцаагчаар ахлуулсан 17 хүн ажиллаж, аймгийн Онцгой байдлын газар, Хөтөлийн гал унтраах анги, Орхон аймгийн Онцгой байдлын газрын хүчээр 18-ны өдөр бүрэн унтраасан. Урьдчилсан байдлаар нийт 210 га газар шатсан байна.

Сумын хүн амыг дундах “Сүрьеэ өвчний талаархи мэдлэг, хандлага, дадал”-ыг тодорхойлох судалгааг 10 асуумжаар бэлтгэн явуулж, нийт 600 гаруй өрхөөс авч, судалгааны үндсэн дээр сүрьеэ өвчний талаар дэлгэрэнгүй мэдээлэлтэй болж, гарын авлагыг айл өрх бүрд тарааж өгсөн ба халдварт өвчнийг бууруулахад “ТА БИДНИЙ ОРОЛЦОО” сэдэвт уулзалт ярилцлагыг сумын соёлын төвд зохион байгууллаа. Мөн “Сүрьеэ өвчний таралтыг хязгаарлая” уриан дор нийт иргэдийн дунд АХА тэмцээн, гүйлтийн тэмцээнийг амжилттай зохион байгууллаа.

ЕББДС-ийн 12 дугаар ангийн 56 сурагчдад оюутны хөгжлийн зээлийн журам буюу Засгийн газрын 2016 оны 111 дүгээр тогтоол, 2014 оны 71 дүгээр тогтоол буюу

дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад суралцагчийн тэтгэлэг олгох журмын талаар сургалт хийж, Сүхбаатар сумын Улсын тэргүүний 1 дүгээр сургууль дээр 4-р сарын 17-19-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Бэлчир бүсийн “Сайн хичээл-Үйл ажиллагаа” арга хэмжээнд тус сургуулийн багш нар идэвхитэй оролцож монгол хэл, математик, хөгжим, англи хэл, бага ангийн математик, байгалийн ухааны хичээлүүдээр өрсөлдөн 4-р байр 2, 5-р байр 1 багш шалгарсан.

Мөн ЕББДСургуулийн 1-р ангийн бяцхан сурагчдын “Үсэглэлийн баяр”-ын арга хэмжээ 04 дүгээр сарын 22-ны өдөр хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан.

Ерөө сум:

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газраас “Иргэдээ сонсьё” уулзалт хэлэлцүүлэгийг 03-р сарын 31-нд зохион байгуулсан. Мөн энэ сарын 11-ний өдөр сумын төв талбайд Олон улсын хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сарын аяны нээлтийг зохион байгуулж, тус суманд үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж, төрийн байгууллагууд оролцсоноос гадна “Болд төмөр Ерөө гол” ХХК-ний Баянгол уурхайн төлөөллүүд оролцож, сонирхсон иргэд Эрүүл мэндийн төв болон уурхайн хөдөлмөрийн аюулгүй байдлын хувцас хэрэглэлтэй танилцсан. Энэ ажлын хүрээнд 4-р сарын 19-нд сумын Засаг даргын Тамгын газрын мэргэжилтнүүд болон сумын ҮЭ-ийн төлөөлөл бүхий ажлын хэсэг Баянгол уурхайн ээлжийн ажилчдад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон нийгмийн даатгал, байгаль хамгааллын тухай хууль тогтоомжийн талаар сургалт хийж, 70 гаруй ажилтан хамрагдсан. Иргэдийн хүсэлтийн дагуу золбин нохой устгах ажлыг 4-р сарын 18-20-нд явуулж, 157 золбин нохойг устган ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн.

Аймгийн Стандартчилал, хэмжилзүйн хэлтсийн мэргэжилтнүүд тус суманд ажиллаж, худалдаа үйлчилгээ эрхлэгчдийг тохирлын үнэлгээ хийж, 14 газар тохирлын гэрчилгээ олгож, 38 цахилгаан хилийг баталгаажуулалтанд хамрууллаа.

2017 оны 04-р сарын 06-ны өдөр БОХТ-ийн хамт олон “Ойн тухай” хууль, Ой хээрийн түймэрээс урьдчилан сэргийлье, Шар усны үерийн гарын авлага материалыг 62 иргэнд, загас барихыг хуулиар хориглосон хугацаанд загас барихгүй байх зөвлөмж, сануулгыг 9 иргэнд өгч гарын авлага материал тарааж ажиллалаа.

Ерөө сумын ИТХурал, ЗДТГ-ын 2017 оны 03 дугаар сарын 30-ны өдөр улирал бүр зохиогдох “Иргэдээ сонсьё” мэдээлэл солилцох өдөрлөг арга хэмжээ зохион байгуулагдаж Хөдөө аж ахуйн тасаг 1-р улирлын ажлын товч мэдээлэл буюу малчин, мал бүхий иргэдэд чиглэсэн ажлын талаар танилцуулсан.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Мал эмнэлэг, үржлийн газар, ХААИС-ийн Мал аж ахуйн, биотехнологийн сургууль хамтран зохион байгуулсан бог малын ангилагч-шинжээч бэлтгэх мэргэжлийн курст мал зүйч хамрагдаж, мэргэжлийн үнэмлэх гардан авсан.

Нийгмийн даатгалын шимтгэлд 9 байгууллагаас 9,2сая төгрөг, сайн дурын 87 даатгуулагчаас 6182,2 мянган төгрөг, нийт 15181,3 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл, ЭМД-ын шимтгэлд 24 даатгуулагчын 335,0 мянган төгрөгийн шимтгэлийн орлого оруулж төлөвлөгөө 96 %-тай байна. Энэ сард НД-ын сайн дурын даатгалд нийт 17 даатгуулагч шинээр хамрагдсанаас малчин – 10, ХХЭ-0, ажил хөдөлмөр эрхлээгүй иргэн 7 иргэн хамрагдаж гэрээ байгуулсан. Нийгийн даатгалын багц хуулиудыг сурталчлах, хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор гар аргаар алт олборлогч ба бичил уурхай эрхлэгч 101 иргэнд Нийгмийн даатгал, Эрүүл мэндийн даатгалын хувь хэмжээ болон сайн дурын даатгалын ач холбогдлын талаар суртачилж, иргэдийг сайн дурын даатгалд хамрагдах талаар зөвлөгөө өгч, гарын авлага тараан сургалт хийсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, тэдний нийгмийн идэвхи оролцоог нэмэгдүүлэх, чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, эрүүл мэнд, дархлаажуулалтыг дэмжин витаминжуулаланд хамруулах зорилготой ЭМТөв, Соёлын төв, Татварын байцаагч, Халамжийн мэргэжилтэнтэй хамтарч “Бидний өдөр” өдөрлөгийг 85 иргэнийг хамруулан Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, сайн

дурын даатгалын ач холбогдлын талаар хуулийн зөвлөгөө өгч, гарын авлага тарааж мэдээлэл сургалт хийлээ.

2017 оны 04 сарын байдлаар 73 ажил хайгч бүртгэгдэж 5 шинэ ажлын байр бий болон зуучлагдсан байна. Сумын Эрүүл мэндийн төвөөс зохион байгуулагдсан "Сүрьеэгүй сум" дэвжээ тэмцээнд цэцэрлэгийн "Инээмсэглэл" баг амжилттай оролцлоо.

Аймгийн БСУГ, Ерөө сумын Улсын тэргүүний "Нарлаг" цэцэрлэгийн эрхлэгч асан Алтан гадас одонт Н.Лхагвасүрэнгийн нэрэмжит "ЗАЛУУ БАГШИЙН МАНЛАЙЛАЛ" уралдаанд аймгийн нийт 32 залуу багш нар оролцсоноос тус Улсын тэргүүний "Нарлаг" цэцэрлэгийн багш Түвшин овогтой Хандаа амжилттай оролцон бусдыгаа тэргүүлж "ТЭРГҮҮН" байр эзэллээ.

Уран жиргээ"-2017 уран уншлагын аймгийн наадам нь 2017.04.14-ны өдөр Дэлхийн Зөн Монгол Олон Улсын байгууллагын Сэлэнгэ орон нутгийн хөтөлбөртэй хамтран зохион байгуулагдлаа. Уг наадамд 14 сумын 70 гаруй хүүхдүүд 3 насны ангилалаар оролцсон бөгөөд Ерөө сумын Улсын тэргүүний "Нарлаг" цэцэрлэгийн Ж.Оюунтүлхүүр багштай Бэлтгэл "А" бүлгийн Идэрбаяр овогтой Эмүжин 2-р байранд шалгарч Өргөмлөл, Мөнгөн медалиар шагнагдав.

Олон улсын сувилагчдын өдрийг эрүүл мэндийн салбарын хэмжээнд "Эх хүүхдийн эрүүл мэндийн сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулъя" уриан сувилагчийн баярыг угтаж, Сэлэнгэ аймгийн хэмжээнд Сүрьеэгүй –сэлэнгэ болзолт уралдааны зарласантай холбоотойгоор сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх, иргэдэд сурталчлах зорилгоор Эрүүл мэндийн төвийн хамт олон "Эрүүл амьдрал, идэвхтэй хөдөлгөөнд ард иргэдийг уриалсан "Хөдөлгөөн эрүүл мэнд" марафон гүйлтийн тэмцээн 04-р сарын 08-ны өдөр 12.00 цагт Ерөө сумын гүүрэн дээр зохион байгуулагдсан. Энэхүү тэмцээнд 40-өөс дээш насны ангилалд тогооч Ц.Уранбилэг I байр, 18-39 насны ангилалд туслах багш Т.Майцэцэг I байранд, бүлгийн багш М.Шүрэнтогтох III тус тус шалгарлаа.

Ерөө суманд үйл ажиллагаа явуулж буй худалдаа үйлчилгээ эрхлэгчид санаачлан улирал бүр "Спиртлэг биш - Спортлог амьдаръя" уриатай спортын арга хэмжээг зохион байгуулж байхаар төлөвлөсөн. 1 дүгээр улиралд "Архи согтууруулах ундаа худалдан борлуулах" тусгай зөвшөөрөлтэй 12 аж ахуй нэгж ЗДТГазар, Цагдаагийн хэсэгтэй хамтран төр төсвийн байгууллага, иргэдийн дунд "САГСАН БӨМБӨГ"-ийн тэмцээнийг 2017-04-14-ний өдөр зохион байгуулан явууллаа. Энэхүү тэмцээний эмэгтэй төрлөөр Улсын тэргүүний "Нарлаг" цэцэрлэгийн "Сонор" баг 2-р байранд шалгарлаа.

Зүүнбүрэн сум:

"Соёл урлаг - бидний хөгжил" байгууллага сурталчлах өдөрлөгийг баасан гараг бүр зохион байгуулж байгаа бөгөөд ерөнхий боловсролын бүрэн дунд сургууль, 14 дүгээр цэцэрлэг, Засаг даргын Тамгын газрын хамт олон амжилттай оролцлоо.

Сумын ажилгүйдлийн бүртгэлд 2 иргэнийг бүртгэж, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, нөхөрлөл хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан 2 иргэнд заавар зөвлөгөө өгч, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяны төлөвлөгөө гарган, төлөвлөгөөний дагуу Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэвтрийг төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийн дунд аялуулж эхэллээ.

Сумын эрүүл мэндийн төв 20 иргэн хэвтэн эмчлүүлж, 258 иргэнд амбулаторын үзлэг хийснээс өвчний учир 184, урьдчилан сэргийлэх үзлэгээр 36, диспансерийн хяналтаар 24, гэрийн идэвхтэй эргэлтээр 9, дуудлагаар 5 иргэнд эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ үзүүллээ.

Эх хүүхдийн эрүүл мэнд хоол тэжээл хөтөлбөрийн дагуу 0-2 насны хүүхдэд олон найрлагат бичил тэжээлийн холимог олгож, сар бүр жинлэн эхчүүдэд хооллолт асаргааны зөвлөгөө өгч, ээлжит товлотт вакцинд 1 хүртэлх насны хүүхдүүдийг 100 хувь хамрууллаа.

Номын богц аяны хүрээнд явуулын номын санг 5 бүлгийн эцэг эхчүүдийн дунд аялуулж, бүлгийн хүүхэд бүр аав, ээжтэйгээ ном унших номонд дуртай болох

боломжийг бүрдүүлэн ажиллаж, “Үлгэрч өвөө, эмээ” ажлын хүрээнд өвөө, эмээ нарыг бүлгийн багш нар урин хүүхдүүдэд үлгэр яриулж байна.

“Авьяас” хөтөлбөрийн хүрээнд ардын дууны “Би дуучин” тэмцээнийг зохион байгуулж тэргүүн байр бэлтгэл “Б” бүлгийн М.Содгэрэл, дэд байр ахлах бүлгийн Б.Гэгээнжаргал нар шалгарч, “УРАН ЖИРГЭЭ” шүлгийн тэмцээнд тэргүүн байр бэлтгэл “Б” бүлгийн М.Содгэрэл шалгарч аймгийн тэмцээнд оролцох эрх авлаа.

Бага ангийн багш нар, эцэг эхчүүдийн хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор “Эцэг эхийн-хишиг өдөр” үйл ажиллагааг зохион байгууллаа. Уг арга хэмжээний хүрээнд бага ангийн 8 бүлгийн дунд бооцоот гар бөмбөгийн тэмцээн зохион байгуулж 1 дүгээр байранд 16 ангийн эцэг эхийн баг хурд шалгарч ус цэвэршүүлэгч, 2,3 дугаар байранд 2б, 4а ангийн эцэг эхчүүд шалгарч проекторын дэлгэцээр тус тус шагнагдлаа.

Сургалтын эрүүл аюулгүй орчин бүрдүүлэхээр 2 кабинетийн гэрчилгээг сунгах, 4 кабинетийг шинээр байгуулан гэрчилгээ авахаар Боловсрол, соёл урлагийн газарт материалаа хүргүүлсэн ба 6 кабинет шаардлага ханган эрхээ авлаа.

Сумын хэмжээнд 33652 толгой мал төллөхөөс 12932 толгой мал төллөж мал төллөлтийн хувь 38.4 хувьд хүрч том малын зүй бус хорогдол нийт малын 6.1 хувийг эзэлж байна.

Байгаль орчин аялал жуулчлалын яамны дэргэдэх “Ой судалгаа хөгжлийн төв”-тэй хамтран Рашаантын эх, Халиуны даваа орчмын 1400 га талбайд хортон шавьжийн судалгаа явууллаа.

Сумын Засаг даргын 2017 оны А/54 тоот захирамжийн хэрэгжилтийг ханган бүх нийтийн хог цэвэрлэгээний ажлыг зохион байгуулж 12 аж ахуй нэгж, 5 төсвийн байгууллага, 140 гаруй иргэд 80 гаруй сурагч, 10 гэрээт ажилчин, 8 тээврийн хэрэгсэлийг хамруулан 200 тн хогийг түрж буллаа.

Өмнө нь гэр бүлийн хэрэгцээнд дундаа хамтран өмчилсөн газрыг гэр бүлийн нэг гишүүнд шилжүүлэх тухай хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэнээр 11 иргэн шинээр газар өмчилж авах эрх үүслээ.

Нийгмийн даатгалын сангаас өндөр настны тэтгэвэр авагч 274 иргэнд 77 сая, тахир дутуугийн тэтгэвэр авагч 85 иргэнд 19.9 сая, тэжээгчээ алдсаны тэтгэмж авагч 28 иргэнд 6.3 сая, цэргийн тэтгэмж авагч 2 иргэнд 750501 төгрөг, үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэвэр авагч 3 иргэнд 925000 төгрөг, жирэмсэн амаржсаны тэтгэвэр авагч 1 иргэнд 839000 төгрөг, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 1 иргэнд 25500 төгрөг, ажилгүйдлийн тэтгэмж авагч 9 иргэнд 2.5 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олголоо.

Өндөр насны тэтгэвэр 1, тахир дутуугийн тэтгэвэр тогтоолгосон 2 иргэнийг тус тус шинээр нэмж бүртгэлээ.

Орхон сум:

Тус сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант сард төрийн хууль тогтоомж, бодлого шийдвэрийг орон нутгийн ард иргэдэд сурталчлах хэрэгжилтийг хангах талаар салбар чиглэл бүрээр хийж хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн сумын Засаг даргаар батлуулан ажилласан.ЗДТГ-ын төрийн албан хаагчдын дунд “НЭГ ШИНЭ САНАА-НЭГ АЖИЛ” нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж иргэд үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжинд тулгуурласан 20 ажил арга хэмжээг тухайн жилийн турш зохион байгуулахаар шийдвэрлэн хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг ханган ажиллалаа. Тус арга хэмжээний хүрээнд төрийн ажил үйлчилгээтэй холбоотой иргэдийн нийтлэг асуултанд хариулах хөтөч болох “ТӨРИЙН ХӨТӨЧ” мэдээ мэдээллийн гарын авлага, сэтгүүлийг эрхлэн гаргаж 80 айл өрхөд, өвлийн улиралд ядарч доройтсон малыг тэжээх арга болон ядарсан малд нэмэлтээр олгож болох эм бэлдмэлийн талаар гарын авлага бэлтгэн 166 малчин мал бүхий өрхөд тарааж, тугал, хурга, ишиг бойжуулах арга болох нялх төлийн арчилгаа маллагааны талаар зөвлөмжийг мөн бэлтгэн хүргэлээ.

4-р сарыг тохижилт бүтээн байгуулалтын сар болгон төр төсвийн байгууллагууд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган ажиллалаа. ЗДТГ-аас “Тохижилт” арга хэмжээг зохион байгуулахаар 11 ажил арга хэмжээг тусгасан

төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан. Энэхүү ажлын хүрээнд сумын ИТХ-аар батлуулсан “Ногоон төгөл” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд төглийн хашааг барих, мод тарих бэлтгэл ажлыг хангах зэрэг ажлуудыг төр төсвийн байгууллагын албан хаагчдын оролцоотойгоор зохион байшуулж, сумын иргэд үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжид тулгуурлан ЗДТГ-ын коридорыг засварлах, төв зам дагуух ногоон байгууламжийн хайсан хашааг засварлах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

“Бүх нийтийн хог цэвэрлэгээний өдөр”-ийг 2017-04-14.15-ны өдрүүдэд зохион байгууллаа. Тус ажлын хүрээнд ЕБС-ийн 6-11 ангийн 72 сурагч нийтийн эзэмшлийн 5 га газрын шатаж болохуйц хогийг, сумын төвийн нэгдсэн хогийн цэгт 41 иргэн 4 га газрын ил задгай хог хаягдлыг түүж шатаах зэрэг цэвэрлэгээний ажлууд хийгдлээ. Мөн төр төсвийн байгууллагууд хуваарьт газруудаа цэвэрлэж, ЗДТГ-ын зүгээс хөдөөгийн Бэлэндалай багийн хогийн цэг, төвийн хогийн нэгдсэн цэгийн хогийг түрж булах ажлыг зохион байгуулж, айл өрхүүд хашаа хорооныхоо хогийг цэвэрлэх зэргээр бүх нийтийн цэвэрлэгээний ажлыг амжилттай зохион байгууллаа. Сумын хэмжээнд 22 га газрын хогийг цэвэрлэсэн байна.

Жил бүрийн 4-р сарыг “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян” болгон зарлаж хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сурталчлах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх зэрэг олон талт арга хэмжээг, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн соёлыг ажлын байранд нэвтрүүлэе” зохион байгуулж, “Аюул осолгүй ажиллахын төлөө” мэдээллийн хавтсыг төсвийн байгууллагуудаар аялуулан бүх ажилтан, албан хаагчдад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, дүрэм журмыг сурталчилж байна.

Төсвийн байгууллага, аж ахуй нэгжээс шимтгэлийн орлого 17945,5 мянган төгрөг, сайн дурын даатгалд 45 даатгуулагчийн 2088,2 мянган төгрөг, ЭМД-д 36 даатгуулагчийн 776,1 мянган төгрөгийг санд оруулж ажилласан.

Тэтгэврийн сангаас:

-Өндөр насны тэтгэвэр- 270 иргэнд 75889,5 мян төг

-Тахир дутуугийн тэтгэвэр-71 иргэнд 16314,4 мян төг

-Тэжээгчээ алдсаны тэтгэвэр-20 иргэнд 4705,0 мян төг

-Цэргийн тэтгэвэр-3 иргэнд 1507,9 мян төгрөгийн тэтгэврийг тус тус тавьж олгосон.

Тэтгэмжийн сангаас: Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж 5 даатгуулагчийн 303,7 мянган төгрөг, оршуулгын тэтгэмж 2 хүнд 2000,0 мянган төгрөг, ажилгүйдлийн сангаас 1 даатгуулагчдад 501,9 төгрөгийн тэтгэмж тус тус олгогдсон.

Аж ахуй нэгж, төсвийн газрын шимтгэлийн тайланг интернетээр шивүүлж баталгаажуулж авсан. Өр авлагын мэдээг сар бүрийн 13-ны дотор аймагт мэдээлэн ажиллаж байна. Шинээр тэтгэвэрт орох 3 иргэний материалыг бүрдүүлж аймгийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэст хянуулахаар хүргүүлсэн. Хаан банк, Төрийн банкаар тэтгэврээ авах хүсэлтэй тэтгэвэр авагчдын өргөдлийг авч шийдвэрлэлээ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн группын сунгалтыг аймагт мэдээлж программд сунгалтыг хийлгэлээ.

ҮОМШӨ-ний сангаас: Санд 1400,0 мянган төгрөгийн хуваарилалтыг хийж 1 хүний 311,7 мянган төгрөгийн тэтгэврийг олгов.

Ажилгүйдлийн санд: Санд 200,0 мянган төгрөгийн хуваарилалтыг хийж. Мөн аймгаас 1000,0 төгрөгний санхүүжилтыг авч 2 хүний 509,8 мянган төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг тооцож олголоо.

ЭМД-ын санд: Санд 5400,0 мянган төгрөгийн хуваарилалтыг хийж, заавал даатгуулагчийн 776,1 мянган төгрөгийн ЭМД-ын санд орууллаа.

Баянгол сум:

Улсын хэмжээнд явагдаж буй өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгааг сумын хэмжээнд зохион байгуулж, 1038 өрхийг хамрууллаа.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяны хүрээнд хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх зорилгоор “Хөдөлмөрийн аюулгүй байдал,

эрүүл ахуйн соёлыг ажлын байранд нэвтрүүлэе” уриан дор зохион байгуулж, 12 аж ахун нэгж байгууллагын 142 ажилтан албан хаагчид оролцлоо.

Нийгмийн халамжийн тэтгэвэрийг 96 иргэнд 12856,7 мянган төгрөг, асаргааны мөнгөн тэтгэмжийг 48 иргэнд 3018,7 мянган төгрөг, амьжиргаа дэмжих мөнгөн тэтгэмж 42 иргэнд 323,3 мянган төгрөг, алдарт эхийн 2-р одонтой 4 эхэд 400,0 мянган төгрөг, жирэмсэн нярай, хөхүүл эх 130 иргэнд 4774,7 мянган төгрөг, ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт 5 иргэнд 652,0 мянган төгрөгийг олголоо. Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр “Болор оргил майнинг”, Хүүгийн хишиг”, Түмэн бут” зэрэг аж ахуйн нэгж, байгууллага, 1 иргэний ирүүлсэн захиалгын дагуу ажил идэвхитэй хайгч иргэдээс 12 иргэнийг ажилд зуучилж, 8 иргэнийг түр ажлын байраар хангасан.

Сумын хэмжээнд бүх нийтийн хог цэвэрлэгээг 4-р сарын 17-оос 23-ны хооронд зохион байгуулж, сумын иргэд болон тус суманд үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниуд идэвхитэй оролцсон.

Авто тээвэр, өөрөө явагч тээврийн хэрэгслийн техникийн хяналтын улсын үзлэг тооллого энэ сарын 14, 15-ны өдрүүдэд явагдаж, 684 тээврийн хэрэгсэл хамрагдсан байна. Мөн НӨАТ-ийн хуулийн дагуу төлбөрийн баримт олгоогүй 4 газарт 14 хоногийн хугацаатай албан шаардлагыг хүргүүлсэн.

Сумын малчид, тариаланчдын нэгдсэн зөвлөгөөнийг 4-р сарын 12-ны дотор зохион байгуулж, малчид тариаланчдын уялдаа холбоог сайжруулах, цаашид эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг хөгжүүлэх талаар хамтарсан шийдвэрүүдийг гаргаж, аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтнүүд мэдээлэл хийлээ.

Хаврын тариалалтын бэлтгэл ажлыг эхлүүлж техник засварын ажлууд эхэлсэн ба 6 аж ахуйн нэгж 1305 га талбайд чийг хаалт хийлээ. Сумын хэмжээнд 70561 эх мал төллөхөөс 4-р сарын 22-ны байдлаар нийт төллөх малын 61 хувь нь төллөж, төл бойжилт 99,3 хувьтай байна.

Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор 76 иргэнд санамж хуудсыг тараан ухуулга сурталчилгааг хийж, Төв аймгийн Сүмбэр сумаас гарсан хээрийн түймрийг унтраах ажилд оролцсон. Мөн сумын хэмжээнд золбин нохой устгах ажлыг зохион байгуулж, 46 золбин нохойг устгалаа.

Тайлант сард шинэ төрсөн 9, гэрлэсэн 1, эцэг тогтоолт 1, нас барсан 4, шилжин явсан 15, шилжин ирсэн 33 иргэнийг бүртгэж, иргэний үнэмлэх шинээр авах 9, сунгалт хийлгэх 2, гээгдүүлсэн 7 иргэн иргэний үнэмлэх захиалж, үл хөдлөх эрхийн гэрчилгээ 3, газрын гэрчилгээг 8 иргэнд олгосон байна.

Сайхан сум:

Гамшгаас хамгаалах тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339, 340 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу гамшгаас хамгаалах дадлага, сургалтыг Гал түймэр унтраах, аврах 61-р ангитай хамтран 03 дугаар сарын 23-ны өдөр 16 цаг 00 минутанд зохион байгуулж, Сайхан сумын Хөтөл хотын төр төсвийн байгууллага, ЦШХК, Төмөр бетон дэрний үйлдвэр, нийт 21-н аж ахуй нэгж, албан байгууллагын 546 ажилтан, алба хаагч, цэцэрлэгийн болон сургуулийн 1623 хүүхэд, нийт 2169 хүн, 7 автомашин хамрагдсан болно.

Аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Манай гудамж-Миний гэр” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд бүх нийтийн цэвэрлэгээг 2 үе шаттайгаар буюу 4-р сарын 08-ны өдөр “Цэвэр орчин-Бидний амьдрал” уриан дор иргэд, оршин суугчдын, 15-ны өдөр “Дэлхий ээж хогонд дургүй” уриан дор сумын нийт аж ахуйн нэгж, төр төсвийн байгууллагуудыг хамруулан зохион байгуулж, давхардсан тоогоор 2050 гаруй хүн оролцсон.

Мөн “Ногоон байгаль бидний ирээдүй” уриан доор 4-р сарын 22-ны өдрийг бүх нийтийн мод тарих өдөр болгон зарлаж, ногоон байгууламж бүхий эко орчин бүрдүүлэх арга хэмжээг зохион байгуулан ажиллав. Уг арга хэмжээнд нийт 25 байгууллагын 320 гаруй ажилтан, албан хаагчид, иргэд оролцож, хүүхдийн паркийн тохижилт-бүтээн байгуулалтад хувь нэмрээ оруулж, Өөрийн байгууллага, найз нөхдийн нэрэмжит “Ногоон төгөл” –ийг байгуулсан байна.

Улсын төрөлжсөн олимпиадуудад багш, сурагчид амжилттай оролцож, 1-12-р ангийн сурагчдын эцэг эхчүүдийн дунд Хүүхэд сурч хөгжихөд эцэг эхийн үүрэг, оролцоо хандлагыг нэмэгдүүлж эцэг эх, багш сурагчдын уялдаа холбоог сайжруулах зорилгоор “Эцэг эхийн чуулга”-ныг зохион байгууллаа. Чуулганыг хүрээнд эцэг эхчүүдийн дунд Нөхөрсөг эрэгтэй, эмэгтэй гар бөмбөгийн тэмцээн мөн “Хүүхэд сурч, хөгжихөд эцэг эхийн үүрэг оролцоо” сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг хийсэн. Тус хэлэлцүүлэгээр 4 асуудлыг хөндөж хэлэлцлээ. Нийт давхардсан тоогоор 72 эцэг эх хамрагдлаа.

Сумын цэцэрлэгүүд нь хаврын улиралтай холбогдуулан хүүхдүүдийг витаминжуулах зорилгоор аарц, чацарганы ундаа, аньсны жүүс, төрөл бүрийн жимсний витаминт үрэл өгөхөөс гадна амин дэмээр баялаг хоол хүнсээр үйлчлэн хүүхдийн дархлааг хоол хүнсээр дамжуулан дэмжих тал дээр анхааран ажилласан. Бага насны хүүхдэд зөвхөн хоол хүнснээс гадна тэдний дархлааг дэмжих зорилгоор өглөө бүр хөдөлгөөнт дасгал болон цэгт иллэг массаж, хоолой зайлах зэрэг ажлуудыг тогтмол хийснээр хүүхдийг өвчлөлөөс сэргийлэн ажиллалаа.

Хүүхдүүдийг тэжээллэг хоол хүнсээр хангах зорилгоор шинэ төрлийн витаминлаг хоол хүнсээр үйлчилж өвчлөлөөс урьдчилан сэргийлж байна.

Аймгийн цэцэрлэгүүдийн залуу багш нарын дунд зохион явуулсан “Залуу багшийн манлайлал” сэдэвт ур чадвар, авьяасын уралдааны 1-р шатыг Номгон 28-р цэцэрлэг амжилттай зохион байгуулсан бөгөөд уралдаанд 32 багш нараас өөрийн сэтгэлгээний ур чадвар, урлагийн авьяас, бүтээлч сэтгэлгээ, багшлах ур чадвар, оюун ухаанаараа бусад багш нараа манлайлан 11-р цэцэрлэгийн багш У.Сарантуяа 2-р байр эзэлсэн. Цэцэрлэг бүр бүлгийн багш нарын дунд “Сайн хөгжүүлэх үйл ажиллагаа” сэдэвт нээлттэй үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэх улмаар үйл ажиллагааныхаа хэлэлцүүлгийг зохион байгуулав.

Сэлэнгэ аймгийн Орхон бүсийн Соёл урлагийн ажилтнуудын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг нөхөрсөг уулзалтанд зориулсан “Бид Соёл урлагийн ажилтнууд” арга хэмжээг 2017 оны 04-р сарын 1,2-нд амжилттай зохион байгууллаа. Тус арга хэмжээг Урлаг, Спортын төрлөөр явуулсан бөгөөд Орхон бүсийн Соёлын төвийн нийт 36 ажилтан оролцсон байна.

Хүүхэд залуучуудын дунд ихээхэн дэлгэрээд буй “Cover” дууны уралдааныг Хөтөл Соёлын ордоноос 2017 оны 04-р сарын 01-ний өдрөөс эхлэн 3 үе шаттайгаар залуучуудын дунд зарласан. Хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, авьяасаа чадвараа нээн хөгжүүлэх, уран сайхны мэдлэг олгох зорилгоор зохиогдож буй уг арга хэмжээний 1-р шат 2017 оны 04-р сарын 08-нд Сайхан сумын 1-р баг 12-р байрны гадаах хүүхдийн тоглоомын талбайд болсон. Тус тоглолтонд Улаанбаатар хот, Хөтөлийн хүүхэд залуучууд, насанд хүрэгчид өөрсдийн сонирхлоор оролцож ая дуугаа хүргэсэн. Цаг үедээ тохирсон энэхүү үйл ажиллагаа олон нийтэд ихээхэн сонирхолд нийцэж, дараагийн шалгаруулалтыг мөн гадаа талбайд зохион байгуулах санал дэвшүүлсэн. Тиймээс хүмүүсийн хүсэл сонирхолд нийцүүлэн Соёлын ордоны хамт олон “Зуны зугаатай цаг” нэртэйгээр 2-р шатны үзүүлэх тоглолтонд оролцох залуусыг бэлтгэж байна.

Сум дундын эмнэлэг нь “Эх хүүхдийн эрүүл мэндийн сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулъя” сэдэвт “Сувилагчийн нэг өдөр” аяныг зохион байгуулж дараах ажлуудыг гүйцэтгэсэн.

-Сайхан сумын 1,2-р багийн алслагдсан айл өрхийн 0-5 насны хүүхэд, жирэмсэн эх, өндөр настанд үзлэг шинжилгээ хийлээ.

-Хэсгийн эмч нар шинээр төрсөн нярай болон анхлан төрөгч ээжүүддээ гэрийн “Сувилахуйн багц”-ыг бэлэглэж эхчүүдэд хүүхдээ хэрхэн асрах, эрүүл саруул өсгөх талаар зөвлөгөө өгч, зарим зүйлийг биечлэн зааж өгсөн. Энэ үйл ажиллагааг дэмжиж Сайхан суманд үйл ажиллагаа явуулдаг Ч.Сонинхүү эрхлэгчтэй Жаргалан эмийн сан, Б.Мягмар эрхлэгчтэй Гавшгай эмийн сан, Ж.Цэрэндаш эрхлэгчтэй Номин шим эмийн сан, Г.Эрдэнэцэцэг эрхлэгчтэй Дэлгэрэх эмийн сангийнхан гэрийн нөхцөлд яаралтай

тусламж үзүүлэх багц бэлдэж хандивласан нь сумынхаа иргэдийн эрүүл мэндийн төлөө хамтдаа хийж буй ажлуудын нэг боллоо.

Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаа нь орон даяар 2017.03.31-ны өдрөөс эхлэн 2017.04.14-ныг дуустал явагдлаа. Улсын хэмжээний компант ажлыг хийж гүйцэтгэхийн тулд Засаг даргын орлогчоор ахалсан 7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдаж ажиллаа. Манай сумын хэмжээнд Сэлэнгэ аймгаас бэлтгэгдсэн 6 тоологч ирж ажилласан ба тоологч нарт хөтөч болж 1,2-р багийн Засаг дарга нар ажилласан. Сумын хэмжээнд нийтдээ 1389 өрх судалгаагаа бүрэн өгсөн ба 10 өрх судалгаа өгхөөс татгалзсан байна. Сумын хэмжээнд өгөгдсөн өрхөө 100%-ын гүйцэтгэлтэйгээр судалгаанд улсын хэмжээний компант ажлыг амжилттай дуусгалаа.

Орхонтуул сум:

Сумын Засаг даргын Тамгын газар нь Засгийн газар болон аймаг, сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймаг, сумын нийгэм, эдийн засгийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлүүдэд тусгагдсан ажлуудын хэрэгжилтийг хангах, төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг хүндрэл чирэгдэлгүй үзүүлэх чиглэлээр доорх ажил, арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. Сумын Засаг даргын зөвлөл 04-р сарын 10-ны өдөр хуралдаж сумын ИТХ-р хэлэлцэгдэх Мал эмнэлгийн үйлчилгээний жишиг үнийг шинэчлэн тогтоох тухай, мал тэжээвэр амьтад, таримал ургамлын болцын үеийн төлбөрийн болон хохирол барагдуулах, татварт авах жишиг үнийг шинэчлэн тогтоох тухай, Ахуйн үйлчилгээний хөгжлийг дэмжих сумын хөтөлбөрийн төслийг хэлэлцэх тухай, Гэрийн нохойг гэрчилгээжүүлж, мал эмнэлэг үйлчилгээнд хамруулахад шаардагдах үйлчилгээний хураамжийн хэмжээг тогтоох тухай, Сум хөгжүүлэх сангийн 2017 оны тэргүүлэх чиглэл, орон тооны бус зөвлөлийн болон хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэх тухай гэсэн асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Мөн Тамгын газраас үзүүлж байгаа үйлчилгээний талаар иргэдэд мэдээлэл өгөх, хууль сурталчилах зорилгоор “Явуулын иргэний танхим” арга хэмжээг зохион байгуулж эхлээд байгаа ба тайлант сард Рашаант тосгон болон сумын төвд зохион байгуулж 50 гаруй иргэнийг хамруулж шинээр батлагдсан болон нэмэлт өөрчлөлт орсон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Ахмад настны тухай хуулиудын танилцуулгыг хийлээ.

2017 онд бүгд 216060 толгой мал тоологдсоос нийт малын 44.5%-ийг буюу 96290 хээлтэгч мал эзэлж байна. Он гарсаар 4308 толгой мал зүй бусаар хорогдсоноос адуу 253, үхэр 648, хонь 1831 ямаа 1576 толгой хорогдсон байна. Зүй бусаар хорогдсон малын 152 толгой буюу 3,5% нь өвчнөөр, 143 толгой буюу 3,3% нь чононд идүүлсэн байна.

Оны эхний төллөх 96290 хээлтэгчийн 59,2% буюу 57045 толгой хээлтэгч мал төллөж гарсан төлийн 99,0% ба 56531 толгой төл бойжиж байна. Үүнээс ингэ 35, гүү 761, үнээ 2348, эм хонь 32746, ямаа 21155 толгой төллөөд байна. Бүгд 514 толгой төл хорогдсоноос унага 16, тугал 46, хурга 241, ишиг 208 хорогдоод байна.

Суманд үйл ажиллагаа явуулж байгаа хувийн Мал эмнэлэг, үржлийн нэгжүүдийн 2016 онд хийсэн ажлын тайлан 2017 хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар хийх ажлын хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна. Хаврын вакцинжуулалтын ажил эхлээд байна. Мал эмнэлэг, ариун цэвэр, ариутгал халдваргүйжүүлэлтийн сарын аяны хүрээнд малчид иргэдэд албан шаардлага, өгч хот орчны хог цэвэрлэх үхсэн малын сэг зэм устгах булах ажлыг хэрэгжүүлэн нийт 62 өрх айл сэг зэмийг цэвэрлэж устгасан.

Хаврын тариалалтын бэлтгэл ажлын хүрээнд чийг хаалт хийх, хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг хийж одоогоор 3560 га-д хийсэн ба уг арга хэмжээнд 16 иргэнийг түр ажлын байраар ханган ажилласнаас гадна Улсын, болон аймгийн тариаланчдын зөвлөгөөнд нийт 13 иргэн аж ахуйн нэгжийг оролцуулж тариалалтын талаар тавьсан зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хаврын хуурайшилт эхэлсэнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын албан даалгавар, захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор сумын засаг даргын “Ой хээрийг

түймрээс хамгаалах, түймэртэй тэмцэх тухай” захирамж, ажлын төлөвлөгөө гаргаж төр, төсвийн байгууллагад хүргүүлэн галын анхан шатны багаж хэрэгслийг бэлтгүүлэн бэлэн байдлыг хангуулан ой хээрийн болон объектын гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлж ажиллах талаар заавар, зөвлөмж өгч ажиллалаа. Мөн гурван багийн хэмжээнд хавар, намрын цагт буюу түймрийн идэвхтэй үед урамшуулалт морин эргүүлүүдийг томилон эргүүл хийх газруудыг хувиарлан ажиллуулж, сумын төвийн хүнсний дэлгүүрүүд болон ШТС-уудтай ой хээрийн түймэр гарсан нөхцөлд шатах тослох материал болон хүнсний бүтээгдэхүүнээр хангаж ажиллах, хамтран ажиллах тухай гэрээ байгуулан ажиллаж байна. Ард иргэдийг хаврын хуурайшилтын үед галын аюулаас урьдчилан сэргийлэх талаар санамж бичиг анхааруулга гарган танилцуулж нийт давхардсан тоогоор 156 иргэнд ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар анхааруулж гарын үсэг зуруулан ажилласан байна.

Хоггүй сум болох уриалгын дагуу бүх нийтийн цэвэрлэгээ хийх, нэг сарын аян зохион байгуулах тухай сумын Үасаг даргын А/47 тоот захирамж гарч энэ сарын 05-ны өдрөөс 05-р сарын 05-ны өдрийг хүртэл зохион байгуулж байна. Нийтийг хамарсан их цэвэрлэгээний ажлыг амралтын өдрүүдэд зохион байгуулсан ба орон сууц, гэр хорооллын ойр орчим, гудамж, нийтийн эзэмшлийн зам талбай, Туул голын эрэг дагуух газраар болон хог хаягдлын нэгдсэн цэгийн ойр орчмыг 3 удаагийн давтамжтайгаар цэвэрлэн зөөвөрлөн шатааж булж дарсан ба нийт давхардсан тоогоор 260 иргэн, 25 аж ахуйн нэгж байгууллага, 12 машин хамрагдсан байна. Мөн сумын төвийн болон Шар-Ус 1-р баг Рашаант тосгоны ойр орчмын үхсэн малын сэг зэмийг булж устган ариутгал халдваргүйтгэлийн ажлыг зохион байгууллаа.

Тайлант сард нийгмийн халамжийн тэтгэвэрийг 37 хүнд 5128670 төгрөг, нөхцөлт мөнгөн тэтгэмжийг 24 хүнд 1655470 төгрөг, жирэмсэн амаржсаны тэтгэмжийг 28 эхэд 1120000 төгрөг, Алдар цолтоны тусламжийг 4 хүнд 650000 төгрөг тус тус олгосон байна.

Халамжийн тэтгэвэрт шинээр 1 иргэн, байнгын асаргаа шаардлагатай ахмад настныг асрах тэтгэмжид шинээр 3 ахмад настан, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асрах тэтгэмжид шинээр 2 иргэн, байнгын асаргаа шаардлагатай хүүхдийг асрах тэтгэмжид шинээр 1 хүүхдийг тус тус хамруулж шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлэн хамрууллаа.

Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн хүрээнд 13 ахмад настанд, хөгжлийн бэрхшээлтэй 6 иргэнд шүдний хөнгөлөлт тус тус үзүүлсэн байна. Рашаан сувилалд 7 ахмад настанг хамрууллаа. Жирэмсэн эхийн тэтгэмжид шинээр 5 эхийг бүртгэж, хувийн хэрэг нээж дээд шатны байгууллагад хүргүүлээ. Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгааг 2017 оны 3-р сарын 31-ний өдрөөс эхлэн 10 хоногийн хугацаанд зохион байгуулахад Баянцогт 2-р багийн 284 өрх, Хонгор-Овоо 3-р багийн 103 өрх, Рашаант тосгоны 398 өрх хамрагдлаа.

Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Спортын баг хамт олон” шалгаруулах спортын олон төрөлт тэмцээн 04-р сарын 06-08-ны өдрүүдэд шагайн харваа, гар бөмбөг, сагсан бөмбөг, теннис, шатар, буухиа төрлүүдээр зохион байгууллаа. Уг тэмцээнд нийт давхардсан тоогоор 160 гаруй тамирчид оролцсон байна. Тэмцээний нийлбэр дүнгээр Бүрэн дунд 1-р сургуулийн баг тамирчид 26 оноогоор тэргүүн байр эзэлж өргөмжлөл, мөнгөн шагналын эзэн боллоо.

Баруунбүрэн сум:

Сумын хэмжээнд 920 толгой мал буюу адуу 40, үхэр 160, хонь 350, ямаа 370 толгой мал хорогдож, 38222 толгой мал төлөлснөөс ингэ 1, гүү 20, үнээ 1520, эм хонь 22640, эм ямаа 14041, толгой буюу тугал 72, хурга 420, ишиг 450 толгой хорогдож 37280 толгой буюу ботго 1, унага 20, тугал 1448, хурга 22220, ишиг 13591 бойжиж байна. Мал эмнэлэг, эрүүл ахуй, ариутгал халдваргүйжүүлэлтийн сарын аяны хүрээнд зүй бусаар хорогдсон бодын 71, богийн 123, сэг зэмийг цуглуулан ариутгал халдваргүйжүүлэлтийг 560м² талбайд хайкофын уусмалаар 3 удаа хийж булж устгасан.

Аймгийн Онцгой байдлын газар болон холбогдох мэргэжлийн байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн заавар зөвлөмжийг иргэд олон нийтэд сурталчилан, тус шийдвэрийг үндэслэн Ойд явуулах үйл ажиллагааг түр хугацаагаар хязгаарлаж, хуурайшилтын үед ажиллах “Хариуцлагатай жижүүр” болон “Морьт эргүүл”-ийг томилсон. Хаваржилт хүндэрч малын хорогдол гарч сэг зэм ихээр хаягдах болсонтой холбогдуулан “Сэг зэм” устгах 2 цэгийг тогтоон тэмдэгжүүлж, хог хаягдлын нэгдсэн цэгийн хог хаягдлыг цэгцлэж, овоолго хийж замыг чөлөөлж, зориулалтын бус 3 газарт хуримтлагдсан 13,5 тн хог хаягдлыг цэвэрлэсэн.

Бургалтайн 2 дугаар багийн нутаг “Бүдүүн Хуст”-д 4-р сарын 18-нд гарсан тал хээрийн түймрийг унтраах ажлыг зохион байгуулан богино хугацаанд цурванд авч, унтрааж түймрийн эзэн холбогдогчид хүлээлгэж өгсөн.

Энэ сарын 20-21-ний өдрүүдэд Улаанбаатар хотод болсон Байгаль хамгаалах нөхөрлөлүүдийн үндэсний 2-р чуулганд “Байгалийн хишиг”, “Бумбат хангай”, “Ногоон сан”, “Түвшинбүрэн”, “Бүрэн тоонч” нөхөрлөлөөс төлөөлөл оролцлоо.

Сумын Ерөнхий боловсролын сургуулиас сургалт хүмүүжлийн ажлын талаар Монгол зан заншил мөн Зөв Монгол хүүхэд хөтөлбөртэй уяалдуулан “Дөрвөн бэрх” тэмцээнийг зохион явуулж, 54 эцэг эхчүүд, 6-12-р ангийн сурагчдын дунд зохион байгуулсан сургуулийн аварга шалгаруулах Үндэсний бөхийн барилдаанд 42 суралцагч оролцож, шалгарсан тамирчдыг шагнаж урамшуулсан.

Шаамар сум:

Орон нутагт цахим засаглалыг хөгжүүлэх, мэдээллийн ил тод байдлыг хангах, иргэн төвтэй төрийн тогтоцоог бэхжүүлэх зорилгоор сумын цахим хуудасны www.shaamar.se.gov.mn/ тасралтгүй ажиллагааг хангах үүднээс цахим хуудсанд мэдээлэл нийтлэх ажлын төлөвлөгөөг төр төсвийн байгууллагуудын дарга эрхлэгч нарт танилцуулан баталгаажуулж, 04-р сарын байдлаар 20 төрлийн цаг үеийн мэдээ мэдээллийг байршуулаад байна.

Сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн гишүүдийн хуралдаан 04-р сарын 13-ны өдөр болж, ГХУСАЗСЗ-өөс 2017 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд хамтран ажиллах гурвалсан гэрээг орон нутгийн төр төсвийн байгууллагуудын удирдлага, зөвлөлийн гишүүдэд танилцуулж, гэрээнд тусгах саналуудыг нэгтгэн гишүүдтэй гурвалсан гэрээг байгууллаа.

Иргэдэд хуулийн мэдлэг олгох сургалт сурталчилгааны ажлын хуваарийн дагуу иргэний бүртгэлийн ажилтан хуулийн этгээдийн эрхийн улсын бүртгэлийн талаарх мэдээлэл, нийгмийн даатгалын байцаагч “Даатгуулагчийн танд” сэдвээр сургалт сурталчилгааг хийлээ.

“Тариалан эрхлэлтийг дэмжих сан”-аас бага оврын тракторын зээл, Чацарганы суулгац зээлээр авсан иргэдийн жагсаалтыг гаргаж холбогдох газарт хүргүүлсэн. Мөө сумын малчид, зөгийчид, тариаланчид өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн нэгдсэн зөвлөгөөнийг зохион байгуулж, нийт 152 иргэн оролцлоо.

Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх тухай хариуцлагын гэрээг ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөлүүдтэй байгуулж, аймаг, сумын Засаг даргын захирамжаар Бүх нийтийн хог цэвэрлэгээг 4-р сарын 12-ны өдөр зохион байгуулж, 12 байгууллага хамрагдан нийт 30 гаруй тн хогийг ачиж, 40 га газрыг цэвэрлэлээ.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтэнд хяналт тавьж цагдаагийн хэсэгтэй хамтран эргүүл хийж 5 тээврийн хэрэгслийг түр саатуулж зохих арга хэмжээг авч Сүхбаатар сумын 16 иргэнд 85м³ хайргыг олгож 400 гаруй мянган төгрөг, Шаамар сумын 8 иргэнд 18 м³ хайргыг зохих зөвшөөрлийн дагуу олгож 50,0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн.

Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу 4 иргэнд 2-р багийн нутаг дэвсгэр нарсан сүүлд 5,5 га газрыг төмс хүнсний ногооны зориулалтаар олгож, газар эзэмших эрх шилжүүлэх хүсэлт гаргасан 3 иргэний 2,5 га газрын эрхийг шилжүүлж, газар эзэмших эрхийн гэрчилгээг барьцаалах 36 иргэний барьцааг бүртгэсэн.

Нийгмийн даатгалын сангийн 2017 оны 4 сарын тайлан тэнцэлээр 23 ажил олгогч, 196 даатгуулагч нийгмийн даатгалын шимтгэл төлж, сайн дурын даатгалд шинээр 3 хүн хамруулж нийт 165 даатгуулагчийн шимтгэлийг сар болон улирлаар төлүүлж, нийгмийн даатгалын дэвтэр болон эрүүл мэндийн даатгалын дэвтрийг тухай бүр нь баталгаажуулан ажиллаж байна.

2017 оны 04 дугаар сард халамжийн үйлчилгээнд хамрагдах 21 өргөдөл хүлээн авч холбогдох баримт бичгийг бүрдүүлэн шаардлагатай материалуудыг амьжиргааг дэмжих зөвлөлөөр хэлэлцэн шийдвэрлэж дээд шатны байгууллагад уламжлан тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжид хамрууллаа.

“Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаа”-ны мэдээлэл цуглуулах ажлыг тогтоосон хугацаанд амжилттай зохион байгуулж сумын хэмжээнд нийт 413 өрхийн судалгааг бүрэн авч дууслаа. “Хүнсний цаасан эрхийн бичгээр хүнсний бүтээгдэхүүн олгох үйл ажиллагаанд хүнсний дэлгүүртэй хамтран ажиллах гэрээ”-ний дагуу хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдсан зорилтот бүлгийн 6 өрхийн 34 гишүүнд 2017 оны 3 дугаар сарын талон болох 48 ширхэг үнэт цаас бүхий 312000 төгрөгний хүнсний бүтээгдэхүүнийг гэрээт байгууллага болох “Бүтээл сан” ХХК-ийн “Шонхлой” хүнсний дэлгүүртэй хамтран олгож олгосон тайланг холбогдох мэргэжилтэнд хүргүүлж ажиллалаа.

4 дүгээр сарын байдлаар сумын хэмжээнд шинээр 9 хүүхэд төрсний гэрчилгээг үнэ төлбөргүй олгож, шинээр иргэний үнэмлэх авах 2, сунгалт хийлгэх 8% партг аюар 1 иргэний материалыг бүрдүүлж, хэвлэгдэн ирсэн 20 иргэний үнэмлэхийг иргэдэд тарааж олголоо.

Хүдэр сум:

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяны хүрээнд төр, төсвийн байгууллага, аж ахуйн нэгжийг төлөөллийг оролцуулан 2016 онд аймаг, сумын хэмжээнд хийсэн ажил арга хэмжээний тайлан, цаашид хэрэгжүүлэх ажлын талаар мэдээлэл хийж, уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй “Дархан Төмөрлөг” ХК-ийн холбогдох мэргэжилтний удирдлага дор үзүүлэх сургалтыг зохион байгуулж, нийт 16 аж ахуйн нэгжийн төлөөлөл оролцсон. Мөн тус суманд үйлдвэрлэл явуулж буй “Тарс” ХХК-ий савхны үйлдвэр, “Хүчин бүрэн” ХХК-ий нойтон баяжмалын үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцлаа.

Аймгийн Засаг даргын захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор “Цэвэр орчин-эрүүл амьдрал” нийтийн хог цэвэрлэгээг зохион байгуулж, аж ахуйн нэгж, төр төсвийн байгууллагууд, иргэдийг хамруулан сумын төвийн хог цэгүүд болон нийтийн эзэмшлийн зам талбай, голын эрэг дагуу, Хүдэр самбараас дошинтын гүүр, дружба уулын эргэн тойрон, наадмын талбайн ойр орчмыг цэвэрлэлээ. Цаашид уг ажлын үргэлжлүүлж долоо хоног бүрийн 5 дах өдрийг цэвэрлэгээний өдөр болгон зарлаж, хуваарийн дагуу цэвэрлэгээг зохион байгуулахаар төлөвлөж байна.

Энэ сарын 25-нд сумын Засаг дарга иргэдтэй уулзах уулзалтыг зохион байгуулж сум орон нутагт хийгдэх хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын талаар мэдээлэл хийж, иргэдийн асуулт, санал шүүмжлэлийг сонслоо.

Ерөө сумын сурагчдын дунд “Спортын бага наадам”-д ЕБС-ийн баг тамирчид 5 төрлөөс оролцож багийн дүнгээр 3-р байрт шалгарсан. Мөн сурагчдын дунд “Хөгжимт гимнасти”-ийн уралдааныг зохион байгуулж, 463 сурагч хамрагдсан.

Аймгийн аварга шалгаруулах “Үндэсний бөх”-ийн тэмцээн, “Дуулан өв-2017” урлагийн бага наадамд сурагчид амжилттай оролцсон.

Хүүхдийн эрүүл мэндийг хамгаалж өвчлөлөөс сэргийлэх зорилгоор “Цэгт иллэг” зааж сургаж эрүүл мэндийн төвөөс 2 удаагийн сургалт хийж 52 эцэг эх, 15 багшийг хамрууллаа.

Тайлант сард эрүүл мэндийн төвөөс эмнэлгийн тусламж үйлчилгээг тухай бүр үзүүлж, 0-15 настай хүүхдийг дархлаажуулах төлөвлөгөө бүртгэлд хамруулж, 31 хүүхдийг бүртгэн авч хамруулаад байна. Хачигт халдвараас сэргийлэх зорилгоор орон нутгийн иргэд болон уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудаас вакцины захиалга авч, улаанбурханы вакцинг 6 сараас 5 хүртэлх насны хүүхдүүдийг хамрууллаа. Эх хүүхдийн ээлтэй орчинг бүрдүүлэх

зорилгоор эмнэлгийн 1 өрөөг хүүхдийн чөлөөт цагийг өнгөрүүлэх зорилгоор тохижуулж, “Эх хүүхдийн эрүүл мэндийн сувилахуйн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулъя” уриан дор Сувилагчийн нэг өдөр аяныг зохион байгууллаа.

Сумын соёлын төвөөс тайлант сард 10 ажлыг төлөвлөн хэрэгжүүлсэн ба “Ардын дууг хэн сайн дуулах вэ” тэмцээн, Лхагва гариг бүр нийтийн бүжиг, соёлын төвийн бүжгийн дугуйланг тус тус зохион байгуулж, “СУИС-ийн богино дуу дуулаачийн ангийн оюутнуудын болон “Харш” хамтлагийн дуучин Баяртын “Миний аялгуу” тайлан тоглолтыг тус тус зохион байгууллаа.

Сүхбаатар сум:

Сумын түүхт 80 жилийн ойн арга хэмжээг энэ онд тэмдэглэхтэй холбогдуулан сумын төр төсвийн байгууллага болон аж ахуйн нэгжүүдийн удирдах ажилтнуудтай хүндэтгэлийн уулзалтыг зохион байгуулж, ойг угтан хийгдэх арга хэмжээ, бүтээн байгуулалтын ажлуудыг танилцууллаа.

Тохижилт үйлчилгээний газар нь нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор хилэн, хун цэцэг, намуун, ценна, хонгорзул, космос, астра, сараана, балжингарам, мандарваа зэрэг 10 гаруй төрлийн цэцгийг 35000 ширхэг тарьж, цэцгийн салгалт хийн усалгаа, арчилгааг хариуцан ажиллаж байна.

Улс орон даяар зохион байгуулагдсан “Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаа”-г зохион байгуулж, жил бүрийн 4 сарыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян болгон зохион байгуулдаг уламжлалт дагуу аймгийн ХАБЭА-н салбар хороотой хамтран энэ сарын 05-нд “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн соёлыг ажлын байранд нэвтрүүлэе” уриан дор Партизаны талбайд зохион байгуулж, 35 аж ахуй нэгжийн 320 ажилтан албан хаагчид оролцон жил ирэх тусам тэдний оролцоо өсөн нэмэгдэж байна. Аяны хүрээнд Үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх комиссын гишүүдийг чадавхжуулах нь, ХАБЭА-н соёлыг хэвшүүлэх нь, Үйлдвэрийн ослоос урьдчилан сэргийлэх нь сэдвүүдээр мэргэжлийн хүмүүсээр сургалт хийлгэж, 80 гаруй ажилтан албан хаагчид хамрагдсан.

Аймгийн Засаг даргын 2017 оны А/153 тоот захирамжаар батлагдсан “Хүний эрхийн төлөө хамтдаа” аяны хүрээнд Сүхбаатар сумын баг бүрт ажлын хэсэг байгуулан хийх ажлын чиглэл, ажлын төлөвлөгөөг гарган, Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн аймаг, орон нутаг дахь хэрэгжилтийн талаар иргэд, олон нийтийн санал бодлыг судлан дүгнэлт гаргахаар баг бүрт хүний эрхийн зөрчлийн талаар судалгааг авч нэгтгэлээ.

Мөн Гэр бүлийн хүчирхийллийн хуулийн шинэчилсэн найруулгыг танилцуулах “Хамтарсан баг-ийн үйл ажиллагааны талаар хуульд орсон заалтуудаар сургалт зохион байгуул, сургууль, багийн нийгмийн ажилтнууд, болон багийн Засаг дарга, хэсгийн цагдаа, өрхийн эрүүл мэндийн төлөөлөл, нийт 40 хүнийг хамруулан зохион байгуулсан. Хүүхдийн тэвчишгүй хүнд хөдөлмөр эрхэлдэг унаач хүүхдүүдийн судалгааг шинэчлэн гаргаж хурдан морь уяач болон эцэг эхчүүд унаач хүүхдүүдийн төлөөллийг аймгийн хэлэлцүүлэгт хамрууллаа.

Хичээлийн жилийн төгсөлт болох гэж байгаатай холбогдуулан МУ-ын Технологийн дээд сургууль, ОХУ-ын Плехановын нэрэмжит Эдийн засгийн их сургууль, эдийн засаг бизнесийн Этүгэн дээд сургууль зэрэг сургуулиуд танилцуулгаа ирүүлэн хамтран ажиллах хүсэлт тавьж байгааг сургуулиудад уламжлан төгсөгчдөд сурталчилсан.

Сумын хэмжээнд мал төллөлт, төл бойжилтын мэдээ, том малын зүй бус хорогдлын мэдээг тус тус хүргүүлсэн бөгөөд нийт 8911 мал төллөхөөс 4200 мал төллөж, төллөлт 47%-тай байна.

Сумын Засаг даргын баталсан удирдамжийн дагуу ОУХТөвд загас загасан бүтээгдэхүүн худалдан борлуулж байгаа болон загасны хорио эхэлсэнтэй холбогдуулан, ХЭААБайдал сарын аян, иргэдийн ажлын байрны эрүүл ахуйн үйл ажиллагаанд хяналтыг хийж ажилаллаа. Шалгалтын явцад дээрх загас худалдан борлуулж байгаа иргэдийн загасны нөөцийг гэрт нь очиж үзэн фото зурагаар баталгаажуулан эрүүл ахуйн шаардлага хангаж ажиллах талаар зөвлөгөө өглөө. Мөн аймгийн Мэргэжлийн хяналтын газартай хамтран хүнсний худалдаа эрхэлж байгаа

худалдагч нарт “Аюулгүй хүнс”, “Түргэн гэмтэх бүтээгдэхүүний хадгалалтын горим”-ын талаарх мэдээ мэдээлэл сургалтыг өгч ажилаллаа. нийт 16 иргэн хамрагдсан байна.

Жавхлант сум:

Сумын ИТХ-ын тэргүүлэгчдээс Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн дагуу сонгуулийн сурталчилгаа хийх байршлыг тогтоож тогтоол гаргасан.

2017 оны хаврын тариалалтын ажил эхлэхтэй холбогдуулан Улаанбаатар хотод зохион байгуулагдсан Улсын тариаланчдын зөвлөгөөнд 10 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид хамрагдаж, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяны нээлтийг “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн соёлыг ажлын байранд нэвтрүүлэе” уриан дор зохион байгууллаа.

Сумын 40 жилийн ойг зохион байгуулахтай холбогдуулан нутгийн зөвлөлийн уулзалтуудыг Улаанбаатар, Дархан Уул аймаг болон аймгийн төвд тус тус зохион байгуулж, сумын Засаг даргын Тамгын газраас цаг үеийн мэдээлэлийг айл өрхүүдээрхийж, албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгаа, 2018 оны орон нутгийн хөгжлийн сангаас хийгдэх ажлын саналыг авч, иргэдийн санал хүсэлтийг сонсон ажиллалаа.

Улс орон даяар зохион байгуулагдаж буй өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаа явагдаж 372 өрх хамрагдсан. Нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалын сангаасэнэ сард өндөр насны 210 тэтгэвэр авагчид 56382,1 мянган төгрөг, тэжээгчээ алдсаны 17 тэтгэвэр авагчид 3952,0 мянган төгрөг, тахир дутуугийн 67 тэтгэвэр авагчид 16212,0 мянган төгрөг, цэргийн өндөр насны 3 тэтгэвэр авагчид 1531,3 мянган төгрөг, нийт 297 тэтгэвэр авагчид 78078,3 мянган төгрөгийн тэтгэврийг олгосон. Тэтгэмжийн даатгалын сангаас 5 даатгуулагчид 5027,7 мянган төгрөгийн жирэмсэн амаржсаны тэтгэмж тус тус олгосон. Ажилгүйдлийн даатгалын сангаас даатгалын сангаас 4 даатгуулагчид 1974,0 мянган төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж тус тус олголоо.

Сумын Засаг даргын А/11 тоот захирамжаар сургууль цэцэрлэгийн хүүхдийн хоол, үдийн цай, хүнсний чанар аюулгүй байдал хяналт тавих, орон нутгийн хүнсний чанар, хүн амын эрүүл ахуйн аюулгүй баталгаатай үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагын бүтээгдэхүүн нийлүүлэлт, стандартын шаардлага хангасан эсэхэд хяналт тавьж үзлэг шалгалт хийлээ.

Бүжгийн урлагийг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, жанр, гарал үүслийг ялгаж сурталчилж, сургах, бүжгийн анхан шатны мэдэгдэхүүнтэй болгох, хөдөлгөөний эвсэл, хөгжмийн мэдрэмжийг зөв чиглүүлж, бүжгийг урнаар гүйцэтгэх чадварыг эзэмшүүлэх зорилгоор “Гэгээн хүслэн-2017” цэнгээнт бүжгийн тэмцээнийг зохион байгууллаа. Мөн Ерөө бүсийн сурагчдын спортын бага наадам болж ЕБСургуулийн сурагчид амжилттай оролцлоо.

Сумын хэмжээнд 41634 хээлтэгч төллөлхөөс унага 13 тугал 728 хурга 5640 ишиг 4823 нийт 11204 буюу төл бойжилт 26% байна.

Сумын малчид, тариаланч, ногоочдын нэгдсэн зөвлөгөөнийг 2 дахь удаагаа зохион байгуулж, аймгийн мал эмнэлэгийн хэлтэс, Дархан-Уул аймгийн УГТХүрээлэн, аймгийн ХААН банкнаас мэдээлэл өгч, малчид мал бүхий иргэд, таримал ургамал тариалагчдын хамтран ажиллах гэрээний төслийг хэлэлцүүлж А гурвалсан гэрээг байгууллаа.

Иргэдийн амьдрах ая тухтай орчинг бүрдүүлэх, сумын өнгө үзэмжийг сайжруулах, амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй халдварт өвчнөөс сэргийлэх, олон нийтэд хог хаягдлаа зөв ангилж зайлуулдаг дадлыг хэвшүүлэх зорилгоор сумын Засаг даргын баталсан “Бүх нийтийн хог цэвэрлэгээг зохион байгуулах ажлын удирдамж” –ийн дагуу 2017 оны 04 сарын 12-ны өдөр бүх нийтийн хог цэвэрлэгээний ажлыг зохион байгууллаа.

Хушаат сум:

Сумын тариаланч, ногоочдын зөвлөгөөнийг 4-р сарын 4-нд зохион байгуулж, УГТХүрээлэнгийн дэд захирал Б.Баатарцол/Ph.D/ "Цаг уурын өөрчлөлтийн үед буудайн технологи, баримтлах бодлого", Төмс судлалын секторын эрхлэгч докторант Х.Нямгэрэл "Төмс хүнсний ногооны үр сортын асуудал, эрт ургацын төмс тариалах боломж", Жимс жимсгэний секторын эрхлэгч Ph.D Д.Оюунгэрэл "Монгол оронд тариалагдаж байгаа жимс жимсгэний сортууд, тариалах технологи", Жимс жимсгэний секторын ЭШ-ийн ажилтан докторант С.Баттөмөр "Монгол оронд тариалагдаж буй чимэглэлийн мод бут, тариалах технологи" зэрэг сэдвүүдээр илтгэл тавьж, сумын цаг уурч Х.Өлзийсайхан "2017 оны 2-р улирлын цаг уурын төлөв байдал" сэдвээр мэдээлэл хийлээ. Зөвлөгөөнөөс газар тариалангийн үйлдвэрлэлийн хэмжээнд баримтлах бодлого бүхий уриалгыг гарган баталлаа.

Мөн сумын малчдын зөвлөгөөнийг 3-р сарын 31-нд зохион байгуулж 94 малчин мал бүхий иргэд ирж оролцож, аймгийн ХХААГ-ын МАА-аас мэдээлэл, зөвлөгөө өглөө. Малын сэг зэм устгах, хог хаягдал цэвэрлүүлэх тухай Засаг даргын захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор 4-р сарын 1-нээс эхлэн хог цэвэрлэгээг зохион байгуулж нийтийн эзэмшлийн гудамж талбай, хүүхдийн тоглоомын талбайнуудыг цэвэрлэж, "Скирин" ХХК-ний трактороор Ишгэнт хорооллын зөвшөөрөгдөөгүй хогийн цэгийг булуулах ажлыг иргэдийн оролцоотой хийсэн.

Сумын хэмжээнд 927 том мал зүй бусаар хорогдсон ба үүнээс үхэр 170, хонь 325, ямаа 432 толгой мал хорогдсон байна.Хорогдсон хээлтэгчээс үнээ 30,эм хонь 50,эм ямаа 50 нийт 130 толгой мал хорогдсон байна. Нийт дүнгээрээ том мал 3109, хээлтэгч 1657 хорогдсон байна.мал төллөлтийн мэдээнд 155 төл гарснаас тугал 82, хурга 37, ишиг 37 толгойгоор нэмэгдэн өсөн нэмэгдсэнээр 6818 хээлтэгч төллөн 6818 төл гарч 1837 төл хорогдон 4981 төл эсэн мэнд бойжиж байна.Хүн амын хувьд шилжин ирэгсэд 19, шилжин явагчид 12, нийт ХАӨМС-д бүртгэлтэй суурин хүний тоо 1937, нийт өрхийн тоо 565 байна.Хөдөлмөр эрхлээлтийн бүртгэлгүй ажилчдын тоо 29, ажилд зуучлагдсан 5, бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 2, бүртгэгдсэн захиргааны зөрчил 18 бүртгэгдлээ.

2017 оны эхний улирлын гоожингийн орлого 130860 байгаа ба Ойн ангитай 1-р улирлын эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээний зарцуулалтын тайланг гарган 7 иргэнд гарал үүслийн гэрчилгээ олгосон.

Энэ сард сумын Цагдаагийн хэсгээс эргүүл шалгалтаар нийт 29 зөрчил илрүүлэн 20 зөрчилд сануулах арга хэсмжээ авч 9 иргэнийг 665000 төгрөгөөр торгох арга хэмжээ авлаа.

Тайлант сард улсын бүртгэлийн үйлчилгээгээр төрөлт 4, эцэг тогтоолт 1, шилжин явсны 6, шилжин ирсний 11, гэрлэлтийн 1, цахим үнэмлэх дахин авах 4, биеийн давхцахгүй өгөгдлийн 3, үл хөдлөх хөрөнгийн эрхийн 2, газар өмчлөх эрхийн 1, иргэний үнэмлэх дахин олголтын 5 нийт 38 бүртгэл хийгдэн Төрийн сан банкны орон нутгийн дансанд 27100, УБСГ-ын дансанд 119000 төгрөгийн орлого оруулсан байна.

Сумын цэцэрлэгийн хүүхэд өдрийн төлөвлөгөөний биелэлт 1900 хүүхэд хүлээн авахаас 1448 хүүхэд хүлээн авч ирц 76%-тай байна. Бүлгүүдийн ирц ихсэн хөдөө малчдын хүүхдүүд ирж байна. Мөн малчдын хүүхдүүдийг хувилбарт сургалтанд хамруулж даалгавар, зөвлөгөө, зөвлөмж, гарын авлага, сурах бичгийг тараан үр дүн, биелэлтийг нь 5 сард дүгнэхээр ажиллаж байна.

Нийгмийн даатгал болон ЭМД-ын тухай хуулиудыг 4-р сарын 25-ны байдлаар 464 хүнд сурталчилгаа хийн нийгмийн даатгалд болон ЭМД-д малчид, ХХЭ, ажилгүй иргэдийг сайн дурын даатгалд хамруулах талаар танилцуулан ажиллаж тараах материал гарын авлагыг 364 хүнд тарааж, НДШ-д 29 байгууллага, аж ахуйн нэгжийн 61787,4 мянган төгрөгийн, нийгмийн даатгалын сайн дурын даатгуулагч 84 хүний 89427,7 мянган төгрөгийн шимтгэл, эрүүл мэндийн заавал даатгалд 79 хүний 3054,2 мянган төгрөгний хураамжийг тус тус оруулжээ. Шинээр тэтгэвэр тогтоолгох 9 хүний материалыг бодож батталгаажуулан тэтгэвэр тогтоолгох зөвлөгөөг 14 хүнд, ЭМД, НД-д сайн дураар даатгуулах зөвлөгөөг 163 хүнд өгч үйлчиллээ.

Орхон бүсийн “Сайн хичээл” ур чадварын уралдаан Сэлэнгэ аймаг Сайхан суманд зохион байгуулагдсан. Нийт 7 хүний бүрэлдэхүүнтэй оролцон МХ,Орос хэл багш Л.Отгонбаяр II-р байр , Математикийн багш Ө.Буянзаяа II-р байр, Бага ангийн багш П.Саранбилэг II-р байр тус тус эзэлсэн.

Сэлэнгэ аймгийн Хушаат сумын ЕББДС-ийн түүхт 100, 80, 30 жилийн ой угтсан “Их бүтээн байгуулалтын жил”-ийн томоохон ажлын нэг “Энхталын сургуулиа эргэн дурсахуй- Хушаатын сургуулиа хамтдаа дурсахуй” уриан дор АУБ,Ангийн дарга, Үе үеийн ахмадууд урьж уулзалт зохион байгуулсан. Нийт 80 гаруй хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулагдсан. Уулзалтын үеэр Телевизийн бичлэг, хүүхдийн концерт, хүлээн авалт, дурсгалын зураг татуулсан.

Өрхийн амьжиргааны түвшинг тогтоох судалгааг тогтоосон хугацаанд зохион байгуулж,99,9 хувьтай хамрагдсан. Нийт 305 өрх судалгаанд хамруулахаас төлөвлөн ажилласан ба судалгааны явцад 323 өрх тоолж, хөдөөгийн 153 өрхийг хамруулсан.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР